

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ЗУРГААДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурал түүний ажлын хэсэг

- 1. “Алдарт эх”-ийн 1,2 дугаар зэргийн одон гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгууллаа*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 86 дугаар зарлигаар Дорноговь аймгийн харьяат олон хүүхэд төрүүлж, өсгөн, хүмүүжүүлсэн эхчүүдэд “Алдарт эх”-ийн 1 дүгээр зэргийн одонг нийт 14 эхэд, 2 дугаар зэргийн одонг нийт 198 эхэд тус тус олгосон билээ.

Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдрөөр аймгийн “Соёмбо” цогцолборын “Хүндэтгэлийн өргөө”-нд аймгийн ИТХ-ын дарга Сандагдоржийн Түмэнбаяр, аймгийн Засаг дарга Төмөртоогогийн Энхтүвшин нар Сайншанд сумын харьяат эхчүүдэд “Алдарт эх” 1 дүгээр зэргийн одонг 5 эхэд, Алдарт эх 2 дугаар зэргийн одонг нийт 60 эхэд тус тус гардуулан өглөө.

- 2. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүллээ*

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвтэн, үйлчлүүлж буй хүүхдүүдэд Дорноговь аймгийн ИТХ-ын дарга Сандагдоржийн Түмэнбаяр гарын бэлэг гардуулахын зэрэгцээ эрүүл энх, саруул ухаан, эх орондоо хэрэгтэй, ижий, аавынхаа ачийг хариулсан сайн иргэн болж төлөвшихийг хүсэн ерөөсөн юм.

- 3. Дорноговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 11-р хуралдаан 2019 оны 06-р сарын 10-ны өдөр “соёмбо” цогцолборын “Хүндэтгэлийн өргөө”-нд боллоо*

11 дүгээр хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

- “Мод тарьж ургуулсан иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ыг шинэчлэн батлах тухай
- “Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”, Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф батлах тухай
- Журам батлах тухай /Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдын төвд нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад /-ээр оюутан, сурагчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчуулах журам/
- Хөвсгөл, Улаанбадрах сумын хилийн цэсийн санал уламжлах тухай
- Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал уламжлах тухай
- Аймгийн тусгай хамгаалалттай газрын хугацааг сунгаж авах тухай
- Сайншанд сумын 3, 8 дугаар багийн хилийн заагийг баталгаажуулах тухай
- Бусад асуудал /Аймгийн аялал жуулчлалын төлөвлөгөөний төслийн танилцуулга/

4. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 7 дугаар хуралдаан зохион байгуулагдлаа.

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 7 дугаар хуралдаан 06 дугаар сарын 10-ны өдөр боллоо. Тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

1. “Иргэн бүр санаачлагч-Өрх бүр үйлдвэрлэгч” дэд хөтөлбөр батлах тухай
2. “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” дэд хөтөлбөр батлах тухай
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд санал өгөх тухай
4. Төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих тухай
5. Нэрэмжит болгох тухай
6. Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай /Зүүнбаян баг, нефтийн үйлдвэрийн 70 жил/
7. Цэргийн албыг дүйцүүлэх алба хаагчдын хяналтын тоо батлах тухай
8. Дэмжлэг үзүүлэх тухай /Хот тохижилт/
9. Аймгийн ИТХ-ын архивын өрөөг тохижуулахад зардал гаргах тухай
10. Монгол Улсын Төрийн дээд шагналд уламжлах тухай

5. Дэлхийн цусны донорын өдрийг тохиолдуулан шагнаж урамшууллаа.

Хэзээ ч нүүр тулан уулзахгүй, танихгүй хэн нэгэнд сэтгэл харамгүйгээр зориулан ариун цусаа бэлэглэж, бусдын алтан амийг аврагч ачтан доноруудын ариун үйлсийг сурталчлах, алдаршуулах, тэдэнд талархлаа илэрхийлэх боломжийг олгох өдрийг дэлхий нийтээр 2003 оноос эхлэн “Дэлхийн цусны донорын өдөр” болгон тэмдэглэж эхэлсэн түүхтэй.

Энэ жил Дорноговь аймаг нь Аюулгүй цус цусан бүтээгдэхүүн Хэнд ч, Хаана ч гэсэн уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Энэхүү бахархам арга хэмжээг аймгийн “Соёмбо” цогцолборын “Хүндэтгэлийн өргөө”-нд зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд урилгаар аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, Сайншанд сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч С.Одбаяр, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ч.Байгалтуяа, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Ц.Мөнхбаярсгалан, аймгийн Улаан загалмайн хорооны дарга Т.Дэлгэрмаа, Нийгмийн даатгалын дарга Л. Шагдарсүрэн нар ирж нийт эмнэлгийн албан хаагч, донорууддаа баяр хүргэж, сайн сайхныг хүсэн ерөөлөө.

Манай аймгийн цусны салбар төв нь нийт 203 донортой. үүнээс хүндэт донороор 46 иргэн байдаг. Тус хүндэтгэлийн арга хэмжээний үеэр дараах нэр бүхий хүмүүсийг шагнаж, урамшууллаа. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр Ч.Мөнхцэцэг
- Аймгийн ИТХ-ын “Өргөмжлөл”-өөр Л.Батмөнх, Б.Хүрэлтулга, У.Отгонбаяр, Г.Алтангадас
- Аймгийн Засаг даргын Жуух бичгээр У.Лэгдэнгомбо
- Аймгийн Засаг даргын “Өргөмжлөл”-өөр Б.Энхцэцэг, О.Уранчимэг, Ц.Алтанболд
- Сайншанд сумын Засаг даргын “Өргөмжлөл”-өөр Г.Насантогтох, Д.Отгонтуяа

- Сайншанд сумын ИТХ-ын даргын “Өргөмжлөл”-өөр С.Дашнамжил, Балжинням нар тус тус шагнагдлаа.
- Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч байгууллагын шагналаар Л.Шагдарсүрэн даргатай аймгийн Нийгмийн даатгалын газрын хамт олон
- Цусны донор хамт олны өргөмжлөлөөр аймгийн Нэгдсэн эмнэлгийн Л.Мөнхзаяа эрхлэгчтэй дотрын тасгийн хамт олон тус тус шалгарч, шагналын эзэд болсон юм.

6. “Граунд гольф” тэмцээнийг аймгийн итх ивээн тэтгэлээ

Аймгийн аварга шалгаруулах граунд гольцфийн тэмцээн нь Дорноговь аймагт анх удаа зохион байгуулагдаж байгаагаараа онцлог байсан төдийгүй энэхүү тэмцээний анхны түүхийг бичилцэж байснаараа оролцогчдын сэтгэл өндөр байлаа. Тус тэмцээний эрэгтэй төрлийн 1 дүгээр байр мөн 15 метрт анхны цохилтоор эхний бөмбөгийг оруулж “Алтан бөмбөг”-ийн эзэнээр аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, дэд байранд Дорноговь аймгийн мастеруудын холбооны тэргүүн, спортын мастер, дасгалжуулагч С.Чулуун, 3 дугаар байранд Сайншанд сумын иргэн П.Маамдай, эмэгтэй төрлийн тэргүүн байранд Спортын мастер Ч.Батнасан, дэд байранд аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ч.Байгалтуяа, 3 дугаар байранд Сайншанд сумын иргэн Ц.Жаргалсайхан нар оролцлоо.Тус тэмцээнд байр эзэлсэн тамирчдад 06 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах 11 улсын 850 гаруй тамирчид оролцох Олон Улсын “Нөхөрлөл” тэмцээнд оролцох эрхийн батламжийг аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, Дорноговь аймгийн мастеруудын холбооны тэргүүн, спортын мастер, дасгалжуулагч С.Чулуун тус тус гардуулан өглөө. Энэхүү тэмцээний үеэр аймгийн “Хулан” клубын тамирчин Ч.Батнасанг аймгийн ИТХ-ын даргын өргөмжлөлөөр шагнаж урамшуулсан юм.

7. Зүүн өмнөд бүсийн хот тохижилтын байгууллагуудын урлаг, спортын 2 дугаар наадмын үйл ажиллагааг аймгийн итх ивээн тэтгэлээ

Зүүн өмнөд бүсийн Хот тохижилтын байгууллагуудын урлаг спортын тэмцээн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Сайншанд хотод зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Тэмцээнд Багануур, Багахангай, Налайх, Бор-Өндөр, Говьсүмбэр, Замын-Үүд, Сайншандын нийт 100 гаруй тамирчин оролцож, спортын 5, урлагийн 4 төрөлд өрсөлдөж, шилдгүүдээ тодруулах юм.

Тус наадмын нээлтийн арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, Сайншанд сумын Засаг дарга С.Одбаяр нар оролцож тамирчдад амжилт хүсэн баяр хүргэснэг юм. Энэхүү арга хэмжээг аймгийн ИТХ-аас ивээн тэтгэж оролцсон юм.

8. “Монгол улсын үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үзэл баримтлалын асуудал”-аар ард иргэдтийн дунд уулзалт зохион байгууллаа

Дорноговь аймгийн удирдлагууд 06 дугаар сарын 24-ны өдөр аймгийн Саран хөхөө театрт “Монгол Улсын Үндсэн хуульд, нэмэлт, өөрчлөлт оруулах үзэл баримтлалын асуудал”-аар Сайншанд сумын иргэд, хөдөлмөрчидтэй уулзалт хийж, тэдний үзэл бодлыг хуваалцсан юм. Тус уулзалтад нийт 100 гаруй иргэд хамрагдлаа.

9. Архивын ерөнхий газрын шалгалтад хамрагдав

Архивын ерөнхий газраас зохион байгуулсан улсын үзлэгт Дорноговь аймгийн ИТХ хамрагдав. Тус шалгалтыг угтаж Дорноговь аймгийн ИТХ нь архивын тусгай өрөөг тохижуулан ажиллав. Аймгийн ИТХ-ын ажлын албаны нийт албан хаагчид архивын улсын үзлэгээс гарсан зөвлөмж, чиглэлийн дагуу цаашид ажилдаа мөрдлөгө болгон ажиллахаар үүрэг авав.

10. Аймгийн итх-ын даргын өргөмжлөл

06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Аймгийн ИТХ-ын даргын” Хүндэт өргөмжлөл”-өөр нийт 1 иргэн, “Өргөмжлөл”-өөр нийт 22 иргэн тус тус шагнагдаад байна.

11. Аймгийн итх-ын даргын захирамж

06 дугаар сард нийт аймгийн ИТХ-ын даргын 16 захирамж гарсанаас ангилахад Шагнах тухай-6, Дэмжлэг үзүүлэх-8, Буцалтгүй тусламж үзүүлэх тухай-1, Хүндэтгэл үзүүлэх тухай-1 тус тус болно.

12. Аймгийн итх-д ирүүлсэн, явуулсан албан бичиг, өргөдлийн тухайд

Аймгийн ИТХ-ын ажлын албанд нийт 52 албан бичиг ирж, ажлын албанаас нийт албан бичиг гадагшаа 24 байгууллагуудруу явсан болно. Иргэдээс аймгийн ИТХ-д нийт 4 өргөдөл ирүүлснээс хуулийн хугацаанд өргөдлийг бүрэн шийдвэрлэн ажилласан болно. Үлдсэн нэг өргөдөл саналын шинжтэй байсан тул хугацааг нь сунгав.

Хоёр. Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар

1. Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр:

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай үүрэг чиглэлийг төрийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг нэгтгэн гаргалаа.

Төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдлийг журмын дагуу шинэчлэн бүрдүүлсэн.

Төрийн ажлын зохион байгуулалт, архивын улсын үзлэгийн хүрээнд байгууллагын холбогдох үйл ажиллагааг шалгуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргасан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмыг нийт албан хаагчдаар хэлэлцүүлэн байгууллагын даргаар батлуулсан.

Төрийн албаны салбар зөвлөлийн 2019 оны эхний хагас жилийн тайланг гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/475 дугаар захирамжийн дагуу нийт 14 сумын 64 багийн Нэгдсэн сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Эрдэнэ сумын Бүрдэнэ багт зохион байгуулсан. Сургалтад аймгийн Цэргийн штаб, Онцгой байдлын газар, Статистикийн хэлтэс, Тогтвортой амжиргаа-3 төслийн орон нутаг дахь төлөөлөгч, Сэтгэл судлалын академийн төлөөлөл оролцсон.

2. Нийгмийн бодлогын чиглэлээр:

Нийгмийн даатгалын хэлтэс:

Нийгмийн даатгалын сангийн орлого зарлага: Нийгмийн даатгалын хэлтэс 2019 онд нийгмийн даатгалын санд 29949216,3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 16578 иргэнд 41934483,0 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгохоор ажиллаж байна.

Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага: 2019 оны 05 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын санд 11496777.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 14276311.76 мянган төгрөгийг төвлөрүүлж, сангийн орлого 124.18 хувийн биелэлттэй байна. Нийгмийн даатгалын сангаас 11734 иргэнд 17241951.66 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгож ажиллалаа.

Үүнийг сан тус бүрээр харуулбал:

Орлого /Мян.төг/

Нийгмийн даатгалын сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	9343081.6	10783257.50	115.41
Тэтгэмжийн даатгалын сан	970088.3	1222027.12	125.97
ҮОМШӨ-ний даатгалын сан	981113.2	1780719.92	181.50
Ажилгүйдлийн даатгалын сан	202494.5	490307.22	242.13
Дүн	11496777.60	14276311.76	124.18

Зардал /Мян.төг/

Нийгмийн даатгалын сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
		Мөнгөн дүн	Хувь	Хүний тоо
Тэтгэврийн даатгалын сан	15409337.20	15246527.33	98.94	8359
Тэтгэмжийн даатгалын сан	1321009.80	1210889.73	91.66	2964
ҮОМШӨ-ний даатгалын сан	362931.00	371579.07	102.38	178
Ажилгүйдлийн даатгалын сан	413793.90	412955.53	99.80	233
Дүн	17507071.90	17241951.66	98.49	11734

1.1 Тэтгэврийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэвэрт нийт 8359 иргэнд 15241607,9 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. Үүнд:

Мян.төг

Тэтгэврийн даатгалын сан	Тэтгэвэр авагчийн тоо	Олгосон тэтгэвэр
Өндөр насны тэтгэвэрт	6136	11341391.52
Тахир дутуугийн тэтгэвэрт	1281	1784885.95
Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт	504	740996
Цэргийн тэтгэвэр	438	1374334.5
Дүн	8359	15241607.97

1.2 Тэтгэмжийн даатгалын сангаас нийт 2964 даатгуулагчид 1209480,23 мянган төгрөгийн тэтгэмж олгосон.

Үүнд:

Тэтгэмжийн даатгалын сан	Тэтгэмж авагчийн тоо	Олгосон тэтгэмж
ХЧТА	2298	294766.84
ЖА	528	776713.39
Оршуулга	138	138000
Дүн	2964	1209480.23

1.3 ҮОМШӨ-ний даатгалын сангаас 178 даатгуудагчид 371579,07 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон. Үүнд:

ҮОМШӨ-ны даатгалын сан	Тэтгэвэр, тэтгэмж авагчийн тоо	Зарлага
Тахир дутуугийн тэтгэвэр	121	294874.35
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	29	63349.39
Тэтгэмж, төлбөр	20	11189.33
Сувилалын зардал	8	2166
Дүн	178	371579.07

1.4 Ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 233 даатгуулагчид 326942,04 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Хоёр. Нийгмийн даатгалын сангийн авлага

Мянган төгрөг

Сангийн авлага	2018.12.31-ны байдлаар	2019.05.30-ний байдлаар
Нийт шимтгэлийн авлага	1515846,5	1872933,32
Төсөвт байгууллага	35086,9	1719527,3

ААН байгууллага	1480759,6	153406,0
-----------------	-----------	----------

Гурав. Өмнөх оны харьцуулалт

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 5 сард

Үзүүлэлт	2018.05	2019.05	2019 5 2018 5
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	10823,1	14276,3	131,9
Тэтгэврийн даатгалын сан	8175,9	10783,3	131,9
Тэтгэмжийн даатгалын сан	925,5	1222,0	132,0
Эрүүл мэндийн даатгалын сан	0	0	0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1349,5	1780,7	132,0
Ажилгүйдлийн даатгалын сан	372,2	490,3	131,7
Нийгмийн даатгалын сангийн зарлага	15253,3	18119,9	118,8
Тэтгэврийн даатгалын сан	13162,5	15246,5	115,8
Тэтгэмжийн даатгалын сан	1041,4	1210,9	116,3
Эрүүл мэндийн даатгалын сан	0	0	0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	729,6	1248,2	171,1
Ажилгүйдлийн даатгалын сан	319,8	414,3	129,5

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 4 сард

Үзүүлэлт	2018.05	2019.05	2019.05 2018.05
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	17321	17305	99,9
Албан журмаар даатгуулагчид	15175	15737	103,7
Аж ахуй нэгж, байгууллага	7633	8186	107,2
Төсөвт байгууллага	7542	7551	100,1
Сайн дураар даатгуулагчид	2146	1568	73,1
2. Тэтгэвэр авагчдын тоо	8120	8509	104,8
Өндөр насны тэтгэвэр	5816	6136	105,5
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1209	1281	106,0
Тэжээгчээ алдсаны	520	504	96,9
Цэргийн тэтгэвэр	157	150	95,5

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ 2019 оны 06 сарын байдлаар

Үйлчилгээ	Тоо хэмжээ
Шинэ ажлын байрны тоо:	117 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5-аар буурсан.
Ажилд зуучлагдсан иргэдийн тоо:	1. 279 буюу өмнөх оны мөн үеийнхээс 115-аар өссөн.
Ажлын байрны захиалгын тоо:	2. 300 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55-аар өссөн байна.
Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо:	3. 765 буюу өмнөх оны мөн үеийнхээс 161-ээр буурсан.

- Зохион байгуулсан нийтлэг арга хэмжээ:

“Амжилтын түлхүүр-ХӨДӨЛМӨР” сэдэвт 18-34 насны залуучуудад зориулсан “Ажил х залуучуудыг сэдэлжүүлэх, идэвхжүүлэх, өөрийгөө таньж мэдэх, орон нутгийн болон бүс нут хөдөлмөрийн зах зээлийн тухай илүү мэдээлэлтэй болох, ажил хайх, өөрийгөө илэрхийлэх б хөдөлмөр эрхлэх ур чадвараа хөгжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлэх” зорилготой бүлгийн сургалт модуль хичээлээр зохион байгууллаа.

Тус сургалтанд аймгийн эдийн засагч, нягтлан, дотоод засал чимэглэл буюу архите тогооч, Герман хэлний орчуулагч мэргэжилтэй 25 залуучууд хамрагдлаа.

Сургалтын төгсгөлд Номин ХХК-н борлуулалтын менежер Даваадорж, Enditikei ХХК-н на бичиг Булган, Мэдээлэл холбоо технологийн газрын хүний нөөц Эрдэнэчимэг нар залуучу нээлттэй ажлын байраа танилцуулан ажлын ярилцлагы зохион байгуулж сонгон шалгаруу хийсэн. Мөн 2018 оны “START UP” хөтөлбөрийн хүрээнд “Эсгий жакет” төслөөр 10 сая төгрө санхүүгийн дэмжлэгт хамрагдсан Батсайхан сургалтанд оролцож буй залууст бизнес с хэрхэн хайж олох, төсөл хэрхэн бичих, ажил хөдөлмөр хүний амьдралыг яаж өөрчилдөг та өөрийн туршлагаа хуваалцан чөлөөт ярилцлага хийсэн.

Номин ХХК-д зохион байгуулагчийн ажлын байранд 4, Мэдээлэл холбоо техноло газарт 2 ажил хайгч иргэн ажлын анкет өгч ярилцлагад бэлтгэж байна. Цаашид эдгээр за маань бүгд ажилтай орлоготой болох итгэл дүүрэн боллоо.

Сайншанд сумын ЗДТГ-аас зохион байгуулж буй “Иргэдэд ойр –Төрийн үйлчилгээ” аяны хүрээнд 1,2,3,4,6,7 дугаар багийн “Малчдын өдөрлөг”-т оролцож иргэдэд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаарх мэдээлэл өгч ажилласан.

- Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд:

- Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт шалгарсан ахмадуудын санхүүжилтийг бүрэн шилжүүлж эхний сарын эргэн төлөлтөө хийгээд амжилттай үйл ажиллагаагаа эрхлээд явж байна.

- Ахмадын зөвлөх үйлчилгээнд 15 байгууллага Сайншанд сумаас: АЗДТГазар, ЭМГазар, /1, 4, 5, 6, 13,-р цэцэрлэгүүд, /Мишээлт мана, Агатова өрхийн эмнэлэг/-үүд мөн Замын-Үүд, Улаанбадрах, Даланжаргалан сумдууд тус тус хүсэлт ирүүлсэн байна.

- Хүүхэд хамгаалагч туршилтын хөтөлбөрийн хүрээнд: ХХҮЕГазрын даргын 2019 оны 04 сарын 22-ны өдрийн 1/505 тоотын дагуу “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-нд тулгуурлан,

хүүхэд бүрийг гэрээс сургууль хүртэл, сургуулиас гэр хүртлэх замыг бүрэн хяналтанд авч тэднийг эрүүл аюулгүй зорчиход дэмжлэг үзүүлж, хүүхэд бүрийг эрсдлээс хамгаалах ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран цэргийн тэтгэвэрт гарсан 2 ахмадыг 2019 оны 05 сарын 01-ээс эхлэн гэрээний дагуу хүүхэд хамгаалагчаар ажиллуулж байна. 1008.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн "Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох" арга хэмжээг нийт 20 төсөл ирсэн. Үүнээс: Сайншанд-9, Алтанширээ-1, Айраг-3, Даланжаргалан-1, Дэлгэрэх-1, Замын-Үүд-4, Эрдэнэ-1 төсөл тус тус ирсэн. Чиглэлийн хувьд: Оёдол, арьсан гар урлал, чулуун хөөрөг, бариа засал, дугуй засвар, гагнуур, бууз банш гэх мэт чиглэлийн төслүүд ирсэнээс 8 иргэний төслийг сонгон шалгаруулж 40.0 сая төгрөгийн санхүүжилтээс 30.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн "Хөдөлмөр эрхлэлтийн сургалт"-ыг гар урлалын чиглэлээр 06.17-ноос эхлэн "Оюуны язгуур" сургалтын байгууллагатай хамтран 11 ХБИргэнд зохион байгуулж байна. Сумдаар харуулбал: Сайншанд, Хатанбулаг, Улаанбадрах, Даланжаргалан, Алтанширээ, Мандах,

Дэлгэрэх, Эрдэнэ гэсэн сумдын ХБИргэд хамрагдаж 2288.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Түрээсийн хөнгөлөлт олгох арга хэмжээнд 2017 онд хөтөлбөрт засвар үйлчилгээ чиглэлээр хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч Д.Түвшиндэлгэрт 351.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

3.Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

"Аж ахуй эрхлэлтийн сургалт"-ыг 52 иргэнд Бэст метод ХХК-ны "Бэст инноваци бизнес хөгжлийг дэмжих төв"-тэй хамтран зохион байгуулсан. Сургалтанд суусан иргэдийг сумдаар харуулбал: Сайншанд, Өргөн, Мандах, Замын-Үүд, Эрдэнэ сумдаас залуучууд хамрагдсан.

START-UP арга хэмжээ"-г Вэст метод ХХК-ны Бэст инноваци хөгжлийг дэмжих төвтэй хамтран зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг 2019 оны 06-р сарын 16-ны өдөр хийлээ. Сонгон шалгаруулалтанд 15-34 насны залуучуудын 22 бүлэг оролцож, ХХҮГазрын даргын А/17 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон оролцогч бүлгүүдэд бизнес санаагаа ил тод, нээлттэй танилцуулснаас 10 бүлгийг шалгаруулан хурдасгуур арга хэмжээнд оролцох эрх, 10.0 сая төгрөгийг 36 сарын хугацаатай олгох ЭРХИЙН БИЧИГ гардуулан хурдасгуур арга хэмжээнд хамруулахаар гэрээ байгуулаад байна.

"Дорноговь аймгийн залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажлын удирдлага, зохион байгуулалт, хяналт, үнэлгээ" сэдэвт сургалт-семинарыг Аймгийн удирдлагууд болон Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, ААНБайгууллага болон иргэдийн төлөөллийг оролцуулан ХНХЯамны ахлах мэргэжилтэн Д.Хадхүү, Швейцарын хөгжлийн агентлагын зөвлөх М.Галсансар нар зохион байгууллаа.

4. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

4.1 Санхүүгийн дэмжлэгийн сонгон шалгаруулалтыг үе шаттайгаар зохион байгуулж дуусгасан ба дэмжлэгт хамрагдахаар хүсэлт ирүүлсэн 7 сумын 36 иргэний 179.0 сая төгрөгний төслөөс 20 иргэний 100.0 сая төгрөгний төслийг дэмжин санхүүжилтийг олгохоор шийдвэрлээд байна. Шалгарсан төслийг чиглэлээр нь авч үзвэл:

- Хоол үйлдвэрлэл-6
- Оёдлын үйлдвэрлэл-6
- Засвар, үйлчилгээ-5

4.2. Нийтийг хамарсан ажлыг 12 суманд зохион байгуулахаар шийдвэрлэж, Сайншанд, Улаанбадрах, Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Хатанбулаг, Хөвсгөл, Хатанбулаг сумдын ажлууд хийгдэж дуусаад байна.

4.3 Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 6 бүлэг үйл ажиллагаа эхлээд байна.

5. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд:

Иргэдээс авсан сургалтын хэрэгцээний судалгаа, аж ахуй нэгж байгууллагын ажлын байрны захиалгад үндэслэн хүнд машин механизмын сургалтыг 17 ажилгүй иргэнийг хамруулан аймгийн МСҮТ-тэй хамтран зохион байгуулж байна.

6. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Даланжаргалан, Мандах, Хөвсгөл, Улаанбадрах сумдад малжууах арга хэмжээг зохион байгууллаа. Нийт 11 өрхийг 904 толгой бог малаар малжуулсан бөгөөд хонь 381, ямаа 523 байна. Мал худалдан авахад 53000.0 мянган төгрөгний санхүүжилт гаргасан.

Нийтлэг үйлчилгээний хүрээнд: АМЧБОЗӨ ганцаарчилсан зөвлөгөөг өссөн дүнгээр 254 иргэнд /эмэгтэй 142/, Бүлгийн зөвлөгөө сургалтыг 710 иргэнд /эмэгтэй 416/ өгч ажилласан байна.

Ажил хайгч иргэнийг бүртгэх:

Ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлттэй нийт 186 иргэний бичиг баримтын бүрдлийг бүрдүүлэн анкетийг бөглүүлэн хүлээн авч ХЗЗ-н LMIS программд бүртгэн, тухайн тайлант хугацаанд идэвхгүй төлөвт шилжсэн 163 иргэдийн бүртгэлийг тухай бүрт нь сэргээн ажилласан.

Ажлын байрны захиалга:

Орон нутагт үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ААН, Байгууллагуудтай холбогдож сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг тухай бүрт нь авч 7 хоног бүр өөрчлөн ажилласан мөн сумдаас ирүүлсэн сарын тайлан мэдээнд сул чөлөөтэй ажлын байрны захиалгуудыг нэгтгэн гаргаж мэргэжилтэн бүрт хүргэн мөн телевиз радио болон facebook, пэйж хуудсуудаар зар мэдээг иргэдэд хүргэж ажилласан

Ажилд зуучлах үйлчилгээ:

Сул чөлөөтэй ажлын байрны захиалгын дагуу ажил хайгч иргэдтэй холбогдон мэдээлэл өгч сайншанд суманд 21 иргэнийг ажилд зуучлан ажилласан. Нийт зуучлал аймгийн хэмжээнд өссөн дүнгээр үзвэл 279

Шинэ ажлын байр

Тайлант хугацаанд шинээр 16 ажлын байр бий болсон байна

Нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ТАЛААР:

Аймгийн хэмжээнд 2019 оны 06 дугаар сарын тэтгэвэр, тэтгэмж Төрийн банкаар дамжин нийт 8419 иргэнд 1,231.2 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгогдсон.

2018 оны өр төлбөрийг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 172 дугаар тогтоолоор орон тутгийн төсвөөс барагдуулах шийдвэр гарсны дагуу Аймгийн засаг даргын тамгын газарт үүссэн өр төлбөрийн жагсаалтыг нэгбүрчлэн гаргаж хүргүүлээ.

2. Өмнсангийн талаар:

Аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны 27 өргөдөл хүлээн авсан ба эдгээр өрхүүдээр зочлон судалгаа авах ажил хийгдэж байна. Өмнөх саруудад судалгаа хийгдэж оноо бодогдох үед мэдээлэл зөрүүтэйн улмаас дахин баалгаажуулалт хийгдэх 32 өрхийн мэдээлэл ирсэн ба дахин холбогдож баталгаажуулж ажиллаж байна.

Шинэ төрсөн хүүхдийн эцэг эхийн 76 өргөдлийг хүлээн авч програмд бүртгэн мэдээлэл өглөө.

2018 оны 10 дугаар сараас хойш ӨМНСангийн судалгаанд харагдаж хүүхдийн мөнгө авах хүсэлт өгч хүүхдийн мөнгөн тэтгэмж авах босго оноо хангасан байсан өрхийн хүүхдийн мөнгө 06 сараас эхлэн орлоо. Ингэснээр 1101 хүүхэд нэмэгдэж аймгийн хэмжээнд 23709 хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмж авч байна.

3. ХБИ, ОНОТХҮ-ний талаар

ХБХЭМБНХСалбар комиссын хурлыг 6 дугаар сарын 14, 27-ны өдөр хуралдуулж нийт 33 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай тогтоов.

Мөн Замын-Үүд суманд комиссын хурлыг зохион байгуулж 37 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатайг тогтоолоо.

ХБХүүхдийн бие махбод, танин мэдэхүй,нийгэмшихүйн хөгжлийн ерөнхий түвшинг тогтоох шалгах хуудсыг Сайншанд сумын Хөгжлийн эрхшээлтэй 10 хүүхдээс авч дүгнэлт бичин ХНХЯамны харъяа ХБХЭМБНХТөв комисст хүргүүлэв.

ОНОТХҮйлчилгээ үзүүлэхээр шалгарсан хоёр төрийн бус байгууллагатай 2019 оны 06 сарын 11-нд ХХҮГазрын даргаар батлуулж үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулав. Цаашид тус 2 ТББ-г үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөгөө боловсруулан газрын даргаар батлууж үйлчилгээгээ эхлэх юм. Мөн үйлчилгээнд хамрагдах иргэдийн баримт бичгийг баг дээрээ бүрдүүлж амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж ирүүлэх талаар албан тоотыг Сайншанд сумын засаг даргад хүргүүлэв.

Ахмад настны тухай хуулийн 07 дугаар зүйлд заасан өдрийн үйлчилгээ Даланжаргалан суманд хэрэгжүүлж байгаа ба нийт 20 ахмад настан хамрагдаж байна.

ХБИргэдэд зориулсан “Гар урлал, эсгий урлал”-ын сургалт тус газарт зохион байгуулагдсан ба ХБХүүхдийн асран хамгаалагчид болон ХБИргэдтэй утсаар холбогдож сургалтанд хамрууллаа.

4. ХЭБ-ийн үйлчилгээний талаар:

ХХҮЕГазарт хүнс, тэжээлийн дэмжлэг туслалцаа хариуцсан мэргэжилтэн сургалтанд хамрагдлаа. Уг сургалтын дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд барьж буй бодлого, журам, цаашдын чиг хандлагын талаар сумын мэргэжилтнүүдэд онлайн сургалтыг зохион байгууллаа.

5. Бусад:

МУ-ын Ахмад настны тухай хуулийн 14.1 дээх заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 0211 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн төлөө хамтдаа” хөтөлбөрийн 2.13.6 дах заалтын дагуу ХХҮГ-ын дэргэдэх аймгийн ахмад настны сувиллыг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажилуулж эхэллээ. Одоогоор Зүүнбаян, Хатанбулаг, Өргөн сумын ахмадууд хамрагдаад байна.

Боловсрол, соёл урлагийн газар:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

5,9,12-р ангийн сурагчдаас авах улсын шалгалтыг 5 сарын 27-оос 6 сарын 6-ны өдрүүдэд зохион байгуулж дууслаа. Шалгалтын үед аймгийн төвийн сургуулиудад БСУГ-ын мэргэжилтнүүд хөндлөнгийн хяналт тавьж ажиллалаа. Улсын шалгалтыг сэдвийг сургууль бүр тусгай эрхээр шалгалт эхлэхээс 24 цагийн өмнө БҮТ-ийн даалгаврын сангаас боловсруулан бэлдэж, хувилж битүүмжлэн дүн мэдээг 24 цагийн дотор Боловсролын салбарын мэдээллийн системд хийлгэж, тухай бүрт хяналт хийн баталгаажуулсан.

Шалгалтын дүн:

Шалгалтын нэр	Суралцагчийн тоо	Ирсэн	Тасалсан	Чөлөөтэй	VIII	VII	VI	V	IV	III	II	I
5-р анги Монгол хэл	135 7	1353	1	3	155	344	267	237	126	103	48	76
5-р анги Математик	135 7	1351	1	5	218	181	206	244	187	170	95	55
5-р анги Хүн байгаль	135 7	1349	1	7	219	319	290	281	158	54	21	14
9-р анги Монгол хэл	970	966	1	3	131	218	206	202	92	57	33	31
9-р анги Математик	970	966	1	3	40	83	122	199	131	152	15 7	86
9-р анги Сонгох шалгалт	970	966	1	3	63	158	231	237	145	74	41	21
9-р анги Гадаад хэл	970	966	1	3	89	168	140	177	151	96	75	74

12-р анги Монгол хэл	315	315	0	0	36	59	74	80	32	23	7	4
12-р анги Математик	315	315	0	0	22	38	65	100	31	31	17	11
12-р анги Сонгох шалгалт	315	315	0	0	30	81	81	72	24	23	2	2
12-р анги Гадаад хэл	315	315	0	0	33	67	72	87	23	21	7	5

БСШУС-ын яамны сайдын 2019 оны 3 сарын 19-ны А/156 тоот тушаалын дагуу суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэхийг боловсролын салбарын мэдээллийн системээс хэвлэх технологи анх удаа улс даяар нэвтрүүлж байгааг аймагтаа амжилттай зохион байгуулж дууслаа. Энэ ажлын хүрээнд үнэт цаасан дээр хэвлэх болсонтой холбогдуулж яамнаас ирүүлсэн зөвлөмжийг хүргэж мэдээллэл арга зүйгээр ханган ажилласан. Энэхүү ажлын хүрээнд нэлээдгүй олон сурагчийн монгол бичгээрх нэр УБЕГ-т буруу байсныг засуулан мөн боловсролын салбарын мэдээллийн системд буй алдаа дутагдлыг дор бүр нь мэдээлж шинэчлэл өөрчлөлтийг хийлгэн сургалтын менежерүүд, мэдээллийн системийн ажилтнуудтай хамтран ажиллалаа. 2019 онд 9 ангийг өдрөөр 964, дүйцсэн хөтөлбөрөөр 5 сурагч нийт 969, 12-р ангийг 315 сурагч төгсч байна.

-Бодлогын баримт бичгийн салбарын хэмжээний тайлан, судалгааны нэгтгэлийг холбогдох газарт хүрүүлсэн. Үүнд:

- Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт
- Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт
- Гурван тулгуурт хөгжлийн бодлогын биелэлт
- БСШУСС-аас Аймгийн ЗД-тай байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээний эхний хагас жилийн биелэлт.
- “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Сургууль, цэцэрлэг, дотуур байрын ариун цэврийн байгууламжийн судалгаа
- 8 сард зохион байгуулах сургалтад хамрагдах багш нарын тоон судалгаа
- БСУГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийн тайлан

-Боловсролын чанарын шинэчлэл төслийн 4-р шатанд Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх 7 сургуулийн захиралтай БСУГ-ын дараа төсөл хэрэгжүүлэх гэрээ байгууллаа. 2019 оны ерөнхий шалгалт 6 сарын 17-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж дууссан. Энэ жилийн ерөнхий шалгалтын гол онцлог нь шууд засалтын технологийг нэвтрүүлсэн бөгөөд зохион байгуулалт, засалтын явцад ямар нэг асуудалгүй явагдаж дууслаа. Орос хэлний хичээлээр Замын-Үүд сумын 1-р сургуулийн багш Б.Нарантуяагийн шавь А.Удвал 800 оноо авч бахдам амжилт үзүүлсэн.

2019 оны ерөнхий шалгалтын ирцийн мэдээ: Дорноговь аймгаас ерөнхий шалгалтанд нийтдээ 377 шалгуулагч шалгалтанд орохоор бүртгүүлсэн болно. Шалгалтын ирцийг нэгтгэн авч үзвэл:

№	Өдөр	Хичээлийннэр	шалгалтандир эх	шалгалтандирс эн	шалгалтандирээг үй	хувь
1	VI/17	Монголын улсын түүх	4	2	2	50%
2		Физик	124	111	13	89.5 %
3	VI/18	Хими	51	47	4	92.2 %
4		Газар зүй	13	8	5	61.5 %
5		Англи хэл	225	195	30	86.7 %
6	VI/19	Биологи	48	44	4	91.7 %
7		Математик	254	225	29	88.6 %
8	VI/20	Монгол хэл	188	164	24	87.2 %
9		Орос хэл	6	5	1	83.3 %
10		Нийгмийнтухаймэдлэг	274	237	37	86.5 %
		Бүгд	1187	1038	149	87.4 %

ЕБС-ийг 2019 онд төгсч Суурь боловсрол эзэмшсэн өдрийн ангийн 964, Дүйцсэн хөтөлбөрийн 5 суралцагч, нийт 969 суралцагчид Суурь боловсролын гэрчилгээ, Бүрэн дунд боловсрол эзэмшсэн өдрийн ангийн 315 суралцагчид Бүрэн дунд боловсролын үнэмлэх олгосон ба БББ олгосон тайланг БСШУСЯ-ны ЕББГ-т 6 сарын 21-нд тайлагнасан. 2019 онд ЕБС төгсөгчдөд БДБҮ, СБГ олгосон бүртгэл, 2019 онд олгосон мэргэжлийн зэргийн материалыг архивын баримт болгосон.

Монголын их дээд сургуулиудын консерциумын 2019 оны их дээд сургуулийн элсэлтийн үйл ажиллагааг 6 сарын 24-26-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. МИДСК-ын нийт 1857 хуваарь манай аймагт ирсэн бөгөөд хуваарь сонгохоор 168 хүн бүртгүүлсэн. Хуваарь сонгохоор бүртгүүлэгчдээс: МУБИС-13, ШУТИС-22, ҮБХИС-13, Засагт хан дээд сургууль-1, Их Засаг олон улсын их сургууль-2, Шихихутуг их сургууль-1, АШУҮИС-11, АШУҮИС-ын Сувилахуйн сургууль-1, АШУҮИС-ын Дорноговь дахь салбар сургууль-2, Ач анагаах ухааны их сургууль-1 нийт 67 хуваарь сонголоо.

Цаг үеийн ажлын мэдээлэл: БСШУС яамнаас 06 сарын 06-нд “Салбарын хэмжээний хөрөнгө оруулалт, элсэлтийн ерөнхий шалгалт, тулгамдаж буй асуудлын талаар хийсэн видео хурал”-д БСУГ-ын дарга, төсвийн мэргэжилтэн, статистик, няналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн оролцож боловсролын салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл авч санал солилцсон.

Боловсролын салбараас хэрэгжиж буй улсын төсвөөс эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны явцын талаар БСШУСЯны үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Энхамгалан танилцаж Аймгийн Хөрөнгө оруулалт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Түвшинтөр, ОНӨА ны дарга У.Баярбилэг, БСУГ ын дарга Ч.Отгонбаяр нартай уулзлаа.Боловсролын салбараас 2019 онд 23 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн Үүнд:15 ажил гэрээ байгуулсан.

- 2 ажил гомдол гарч дахин зарласан.
- 5 ажил тендер зарласан
- 1 ажлын тоо хэмжээ тодорхойгүй./Хатанбулаг соёлын төвийн засварыг шинээр баригдаж дууссан соёл спорт цогцолборт шилжүүлэх/

БСУГ дээр Солонгосын олон улсын байгууллага KOICA-ийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан мэдээллийн технологийн танхимд сайн дурын мэргэжилтэн Кан Сүүк Ук багш аймгийн төвийн цэцэрлэгийн багш 70 хүнийг хамруулан мэдээллийн технологийн сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулсан.

“Соёлын биет бус өв”, “Сонгодог урлаг III”, “Чулуун соёл” үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн төсөл, төлөвлөгөөний төслийг боловсруулан Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст цахимаар хүргүүлсэн.

Хөвсгөл суманд “Төрийн одонт алдарт ээжүүд” арга хэмжээнд оролцсон 150 алдарт ээжүүдэд Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг соёлын мэргэжилтэн хийсэн.

ЕБС-ийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нарын суралтыг 06 сарын 10-нд зохин байгуулж нийт 73 хүнийг хамруулан удирдахуйн болон эрх зүй, санхүү, цаг үеийн асуудлаар арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн Статистикийн хэлтсээс зохион байгуулсан “Мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг сайжруулах нь” сургалтад 2 мэргэжилтэн хамрагдлаа. Сургалтаар Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах, төрийн албан хаагчийн статистикийн мэдээг хийж гүйцэтгэхэд баримтлах хууль эрх зүй, аргачлал, арга зүйн мэдээлэл, заавар, зөвлөмжийн талаар мэдээлэл хийгдлээ.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн сургалтад байгууллагын дарга хамрагдаж цаашид анхаарах асуудлын талаар мэргэжилтнүүдэд мэдээлэл өгсөн.

Сургуулийн 10-р ангид элсэн сурах сурагчдын дүнгийн дундажид хяналт тавьсан.

"Алтан зул " наадмын шилдэг багш, хамт олон шалгаруулах уралдааны удирдамжийг сургуулиудад хүргүүлсэн.Монгол улсын авлигатай тэмцэх газрын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 05/4118 албан тоотоор Замын-Үүд сумын соёл спортын ордны удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэн Н.Төрбадрахын гомдол мэдээллийг харьяаллын дагуу шалгуулахаар аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт шилжүүлснийг хүлээн авсан байна. Замын-Үүд сумын Сүлд багийн иргэн Н.Төрбадрахын мэдээлэлд дурдсан асуудлыг шалган шийдвэрлэх ажлын хэсгийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын 2019 оны 6

дугаар сарын 10-ны өдрийн А/36 дугаар тушаалаар томилсны дагуу 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Замын-Үүд сумын соёл спортын ордны удирдлага, ажиллагсдыг байлцуулан ажиллалаа.

-Боловсролын салбарын 2020 оны төсвийн төсөл, 2021, 2022 оны төсвийн төсөөлөл, 2020 оны УТХО-ын их засвар үйлчилгээний төслийг холбогдох заавар маягтын дагуу сумдаас авч нэгтгэж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар:

Нэг. Салбарын болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, дүрэм, журамд санал өгсөн байдал, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд*

Тус сард хүүхдийн тусламжийн утсанд 2 дуудлага бүртгэгдсэнийг харьяаллын дагуу Замын-Үүд, Сайншанд сумдад шилжүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Тус дуудлагуудыг ангилж үзэхэд үе тэнгийн хүүхдүүдийн дунд нэгнээ дарамталж, айлган сүрдүүлсэн, гэр бүлийн орчинд хүүхдийг хараа хяналтгүй орхиж үл хайхрах байдалд өртүүлсэн дуудлагууд байна. Тус 2 дуудлагад ГБХЗХГ-аас нөхцөл байдлын үнэлгээ хийж, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээний болон хүчирхийллийн хохирогч хүүхдийн судалгааг гарган холбогдох шатны байгууллагуудад хүргүүлсэн. Тус судалгаагаар хүчирхийлэлд өртсөн 1 хүүхэд, хөгжлийн үйлчилгээнд 45 хүүхэд хамрагдсан байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн 3 хүүхдийн эрх ашгийг хамгаалж хууль ёсны төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож, холбогдох этгээдүүдэд 18 хүртэл жилийн хорих ялаар шийтгэх шийдвэр гарлаа. Бэлгийн хүчирхийллийн хохирогч 3 хүүхдийн зардлыг хүүхэд хамгааллын зардлаас шийдвэрлэж, нөхөн сэргээх Үжин төвд хамруулан зуслангийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Залуучуудын хөгжлийн төвийн өсвөр үе залуучуудад үйлчилгээ үзүүлдэг 8 суурин компьютерийг ашиглан зорилтот бүлгийн 12 иргэнд компьютерийн анхан шатны мэдлэг олгохсургалтыг зохион байгуулж, 10 хуруугаар шивэх, энгийн хэрэглээний программуудтай ажиллах мэдлэг, чадвар олгож байна

Монголын хүүхдүүд хүүхдийн урлагийн их наадмын 2-т шатны говийн бүсийн шалгаруулалтад Дорноговь аймгийн 28 өсвөрийн авьяастан шалгарч улсын баяр наадамд оролцох эрх авлаа.

Гэр бүлийг дэмжих аяны хүрээнд бага насны хүүхдийн дунд гарч болзошгүй ахуйн ослоос урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор Онцгой байдлын албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Гал хүү, ус хүү” жүжигчилсэн тоглолтыг үзүүлэн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. Цаашид Сайншанд сумын аж

ахуй нэгжүүдийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран бага насны хүүхдүүдэд тус жүжгийг толилуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл болон бусад ял шийтгэлээр шийтгэгдсэн нийт 18 иргэнд ШШГГ-тай хамтран долоо хоног бүр тогтмол амьдрах ухааны сургалт хүргэж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зорилго бүхий Зан үйлд нөлөөлөх сургалтыг аймгийн цагдаагийн газартай хамтарсан төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Тус долоо

хоногт цагдаагийн саатуулах байранд баривчлагдсан нийт 13 иргэнд Харилцааны ур чадвар, Жендерт суурилсан хүчирхийлэл сэдвээр сургалт зохион байгуулж, хүн тус бүрд сэтгэл зүйн оношилгоо явууллаа.

Сайншанд сумын 1,7-р багийн нийт 72 иргэнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн мэдлэг дээшлүүлэх сургалтыг зохион байгууллаа. Мөн сургалтын үеэр хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо сэдэвт хэлэлцүүлгийг эцэг эхчүүдийн дунд зохион явууллаа.

Хүүхдийн өмнө үүрэг хүлээгч бүх талуудын Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ажилтан, албан хаагч нийт 21 иргэнд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлогын баримт бичгийг танилцуулж, эцэг эхийн зөвлөлийг байгуулж ажиллах арга зүйн сургалтыг зохион байгууллаа.

Замын-Үүд сумын сум дундын Шүүхээс ирүүлсэн хүүхдийн асран хамгаалагч тогтоох тухай захирамжийн дагуу байгууллагын даргын 2019 оны А/55 дугаар тушаалаар баталсан шинжээчийн баг томилогдон ажиллалаа. Тус хэрэгт холбогдох нэхэмжлэгч болон хариуцагч талуудтай уулзалт зохион байгуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлтийг заасан хугацаанд нь шүүхэд хүргүүлсэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн Ерөнхий газар, Нийгмийн Эрүүл мэндийн төвийн ерөнхий захирлын 2018 оны хамтарсан А/176, А/223, А/126, А/228, А/49 тушаалаар баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөөний 2.2.6 дахь заалт, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын 2019 оны 01/150 хяналт шалгалтын удирдамжийн дагуу “Цахим тоглоомын газар, интернэт төвүүдэд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх” хяналт шалгалт хийх ажлын хэсгийг байгуулж Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж байгаа 5 цахим тоглоомын газруудад Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, МУ-ын ЗГ-ын 2013 оны 410 дугаар тогтоолоор батлагдсан Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”, “Интернэт кафе, цахим тоглоомын үйлчилгээний байранд тавих шаардлага” MNS 6430:2014 стандартын хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд хяналт шалгалтыг хийлээ.

Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, цаашид хууль журам, стандартыг мөрдөн үйл ажиллагаа явуулах талаар зөвлөгөөг өгч ажилласан.

Хоёр. Төсөв, хөрөнгө оруулалт болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагааны сарын мэдээ, батлагдсан төсөв, тушаал шийдвэр, мэдээллийг Шилэн дансны сайтад сар бүрийн 8-ны дотор байршуулан шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гурав. Төрийн захиргааны байгууллагын манлайллыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах ажлын хүрээнд:

НҮБ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-аас зохион байгуулсан “Оролцоод хөгжье” клубын сургагч багш бэлтгэх сургалт, Амьдрах ухааны модуль сургалтыг зохион байгуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах сургалтад залуучууд хөгжлийн төвийн 2 албан хаагч хамрагдаж жендер, бэлгийн амьдрал, зан үйлийг өөрчлөх арга зүй, залуучуудад зөвлөгөө өгөх арга зүйд суралцлаа.

Үндэсний статистикийн ерөнхий хорооноос статистикийн мэдээлэгч, хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг сайжруулах нь” сургалтад байгууллагын 1 албан хаагч оролцсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2019 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын салбарын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн”-д 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд тус байгууллагын 18 албан хаагч оролцов.

Дөрөв. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар түншлэгч талууд /олон улсын, иргэний нийгэм болон ТББ/-тай хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд:

Цаг уур, орчны шинжилгээний газар, төрийн банк, худалдаа хөгжлийн банк, Капитрон банк зэрэг нийт 4 байгууллагын 68 албан хаагчид амьдрах ухааны модуль хичээлийн хүрээнд “Харилцаа”, “Стрессийг зохицуулах” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулав.

Аймгийн засаг даргын 2018 оны А/339 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд энэ оны 06 дугаар сарын 29-ны өдөр сайншанд сумын 7 багийн зорилтод өрхийн иргэдийн дунд сургалт зохион байгууллаа. Тус сургалтад Сайншанд сумын ЗДТГ, Прокурорын газар, тагнуулын хэлтэс, стандарт хэмжилзүйн хэлтэс, санхүү аудитын алба, эрүүл мэндийн газар 6 байгууллага хамтран 60 гаруй иргэдэд хууль эрхзүй, сэтгэлзүйн болон эрүүл мэндийн зөвлөгөө өглөө.

Тав. Төвлөрсөн болон нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөрт зориулсан арга хэмжээний хүрээнд:

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг 67 дахь жилдээ тэмдэглэн өнгөрүүллээ. Баярын арга хэмжээний хүрээнд ЕБ-ын 1, 2, 3, 5 дугаар сургууль, 12 цэцэрлэгийн авьяаслаг 400 гаруй хүүхэд багачууд баярын жагсаал оролцож, нээлтийн арга хэмжээнд цэцэрлэгийн насны хүүхдүүд болон эцэг эхийн хамтарсан урлагийн тоглолтыг зохион байгууллаа. Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж байгаа 5 аж ахуй нэгж, 14 төрийн байгууллагатай хамтран хүүхэд багачуудын дунд 18 төрлийн хөгжөөнт тэмцээн уралдааныг зохион байгууллаа. Дээрх өдрийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 700 гаруй хүүхэд багачууд хамрагдлаа.

Зургаа. Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилсан ажлын хүрээнд:

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн хүрээнд нээлтийн арга хэмжээг орон нутгийн DTV телевизээр шууд дамжуулж, орон нутгийн 2 телевизэд цаг үеийн мэдээллээр 2 удаа ярилцлага хүргэлээ.

Долоо. Бусад ажлын хүрээнд:

Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны А/396 дугаар захирамжаар Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө, комиссын бүрэлдэхүүнийг байгууллагын даргын 2019 оны А/44 дүгээр тушаалаар батлуулсан. Улсын үзлэгийн хүрээнд төрийн архивт хадгалагдаж буй байгууллагын А даргын 1991-2012 оны тушаал нийт 38 баримтыг цахимд оруулж DVD-д хуулж, байгууллагын архивт хадгалагдаж буй 2016-2018 оны тогтоол, захирамж, тушаал, ирсэн, явсан баримт бичиг, иргэдээс ирсэн өргөдөл, гомдолд нягтлан шалгалт явуулан нөхөн бүрдүүлэлт хийж ажиллалаа.

Ес. Хэвлэгдсэн гарын авлага, брошур, тараах материал:

14 сумдын хамтарсан багт хурдан морь уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай 2 төрлийн гарын авлагыг тус бүр 30 ширхгийг хүргүүлэн ажиллалаа.

Эрүүл мэндийн газар:

ЭМГ-ын 2013 оны А/36 тушаалын дагуу ЭМБ-уудаас эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээг өдөр бүр авч, ЭХЭМҮТ-ийн тандалтын албанд мэдээг дамжуулан, яаралтай тусламжийн зохицуулалтуудыг хийж, дээд шатлалд 13 хүн илгээж, 8 хүнд яаралтай мэс засал хийж, нас баралт, хүндрэлгүй ажилласан.

Жирэмсэн эхчүүдэд “Эхийн сүүгээр хооллолт” сэдвээр сургалт зохион байгуулж, хүүхдээ зөв тэврэх, зөв үмхүүлэх талаар дадлага хичээл орж, нийт 11 жирэмсэн эхэд зөвлөгөө өгөв. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Үр

хөндөлт болон умайн гаднах жирэмслэлт"-ийн талаар 2 төрлийн сурталчилгааны материалын эхийг боловсруулж, 1500 ширхэгийг хэвлүүлэв. 05 дугаар сарын 31 буюу Дэлхийн тамхигүй өдрийг аянг “Өдөр бүрийг тамхигүй өдөр болгоё” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр 8 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилт 100 хувь байлаа. “Өдөр бүрийг тамхигүй өдөр болгоё” уриан дор 20 ЭМБ-ууд 74 удаагийн сургалтаар 640 хүнийг хамруулж, 210 ширхэг гарын авлага тараасан.

“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн даатгалтай гэрээ байгуулсан хувийн хэвшлийн 5 шүдний эмнэлэг 6 дугаар сард нийт 163 хүүхдийг эрүүлжүүлээд байна.

ЭМГ-ын даргын 2019 оны А/43 дугаар тушаалын дагуу сум, өрхийн эмч нарыг АНЭ-ийн сэхээн амьдруулах яаралтай тусламж, хүүхдийн тасгуудад ажлын байрны дадлагажих сургалтанд ээлж дараалалтай хамруулж байгаа ба энэ долоо хоногт Хөвсгөл, Хатанбулаг сумдын багийн эмч нар дадлагажиж байна. Улаанбаатар хотод 2019 оны 06 сарын 07, 08-ны өдрүүдэд Монос фарм болон Монос фарм трейд ХХК-ийн хамтран зохион байгуулж байгаа МОНОС эмийн үйлдвэртэй танилцах аялалд сумын эрүүл мэндийн төвийн 10 эмч мэргэжилтэн хамрагдлаа.

Хүүхдийн төв сувилалтай хамтран “Бага насны хүүхдийн нэмэгдэл хоол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгааны арга зүй” сэдэвт сургалтыг 06 сарын 13, 14-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд эрүүл мэндийн төвүүдийн их эмч, багийн эмч, сувилагч, тогооч нарын нийлсэн 34 хүн хамрагдаж, бага насны хүүхдэд өгөх 21 төрлийн нэмэгдэл хоол болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааг хэрхэн хийхийг дадлага ажлаар хийж сурлаа.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох “Үр хөндөлтөөс сэргийлэх”, “Умайн гаднах жирэмслэлт"-ийн талаар 2 төрлийн 1000 ширхэг сурталчилгааны материалыг хэвлүүлж, зорилтот бүлэгтэй сурталчилгааны материалыг хүргэх зорилгоор Сайншанд суманд үйл ажиллагаа эрхэлж буй 10 эмийн санд 100 ширхэгийг тус бүр тараав.

ЭМГ-ын даргын 2019 оны А/43-р тушаалын дагуу анхан шатны залуу эмч нарыг АНЭ-ийн яаралтай тусламж, хүүхдийн тасагт ажлын байранд дадлагажуулах сургалтанд ээлж дараалалтай хамруулж байгаа бөгөөд энэ долоо хоногт Хатанбулаг сум, Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарыг хамруулан, чадавхжуулав

Сувилагч нарыг чадвахижуулах зорилгоор 3 дахь шатлалын эмнэлэг ШУГТЭ, ЭХЭМҮТ-д сувилагч нарыг 06-10-аас эхлэн ажлын байрны дадлагажих сургалтанд Нийт 11 сувилагчийг хамруулж эхлээд байна.

УАУРСТ-ийн сувилагч нарын баг “Гэрийн сувилахуйн тусламжийг сайжруулъя” сэдэвт аяны хүрээнд Сайншанд сумын 2-р багийн 3 айл өрхийн өндөр настан, хөгжлийн

бэрхшээлтэй 7 хүн, мөн Говийн бүсийн Настны эрүүл мэндийн асрамжийн газрын 15 асруулагч, ажилчид, хүүхдүүд нийт 35 хүнийг үзлэг оношилгоонд хамруулж, өөрт нь болон ар гэрийнхэн асран хамгаалагч нарт нь эрүүл зөв хооллолтын зөвлөгөө, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгон зөвлөгөө зөвлөмж өгч бариа засал, соруул засал эмчилгээ хийж, сахар тодорхойлон, уламжлалт монгол эмээр үйлчилгээ үзүүлэн, эмч, сувилагч нарыг арга зүйгээр ханган, хүчилтөрөгчийн коктейлиор үйлчиллээ. “Уран дэлгэц” эмэгтэйчүүдийн эмнэлгийн ажилтнууд хамтран ажиллаж асруулагч нарын эрүүл мэндийг дэмжиж, дархлаа сайжруулах бэлдмэл гардуулсан

“Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс орон нутгийн төрийн байгууллагуудын удирдлагуудын дунд зохион байгуулах арга зүйн сургалт”-нд 4 хүн хамрагдсан.

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, зөвлөгөө өгөх арга зүй” сэдэвт говийн бүсийн 3 хоногийн сургалтыг зохион байгуулж Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, өсвөр үеийн эмч, сэтгэцийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 60 ажилтан албан хаагчдыг хамруулж хүүхдэд зонхилон тохиолддог сэтгэцийн эмгэгүүд, түүнийг илрүүлэх, зөвлөгөө өгөх аргачлалын талаар мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэв.

Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан тушаалуудын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор “Гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулъя” сэдэвт аянг зарласан. Аяны хүрээнд нийт зорилтот бүлгийн 214 иргэнд гэрээр 7 төрлийн асаргаа сувилгаа хийж, асран хамгаалагч 263 хүнд сургалт явуулж, гарын авлага зөвлөмж тараасан. Гэрийн эргэлтийн иж бүрдэлийг бүрдүүлэхэд сувилагч нар болон байгууллагын зардлаас 750,0 мян төгрөг зарцуулсан

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хяналтын багийнхан ЭМД-ын гэрээ байгуулсан 23 эрүүл мэндийн байгууллагын дарга эрхлэгч нарт хөтөлбөрийн дагуу сургалт хийж, тулгамдсан асуудлыг хэлэлцэж мэдээлэл өгөв.

ЭМГ-ын даргаар ахласан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Зүүнбаян, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумын эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, Сулинхээрийн цэргийн ангийн ажилчин албан хаагчид, ар гэрийнхэнд АНЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын баг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг хийж байна.

ЗҮНЭ-д 2019.06.05-нд төрөлхийн улаан хоолойн битүүрэлтэй төрсөн нярайд ЭХЭМҮТ-ийн хүүхдийн мэс заслын хагалгааны баг яаралтай дуудан АНЭ-т хагалгааг хийн хүүхдийн амь насыг аварч, мөн дутуу төрсөн 2 нярай, бүтэлттэй төрсөн маш хүнд 1 нярайд сурфактант эмчилгээг хийж, амьсгалын аппаратаар удирдан биеийн байдлыг тогтворжуулсан.

АНУ-д хөдөлгөөн засалчаар мэргэшсэн их эмч Ганбаатарыг Шонхор мед эмнэлэг Замын үүд суманд урьж, хөдөлгөөний өөрчлөлт, саа саажил, гэмтлийн дараах хөдөлгөөн хязгаарлагдмал, хэл засал, хөдөлмөр засал, сэргээн засал шаардлагатай иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлж байна. Мөн “Борхойн наран” өрхийн ЭМТ-ийн эмч, сувилагч нарт ажлын байрны сургалт явуулж, сэргээн засах, хөдөлгөөн засал эмчилгээний ач холбогдол, элбэг тохиолддог эмгэгүүдийн үеийн сэргээн засах эмчилгээний аргуудаас танилцуулан шинэ мэдээллээр ханган чадавхжуулав.

УБ хотын Эмгэг судлал шүүх эмнэлгийн төвийн Н.Басхүү, Б.Энхчулуун эмч нарыг урьж, эмч нарт Онош зүй, эмнэлзүйн ур чадварыг дээшлүүлэх, оношийн шийдэл зэрэг сэдвүүдээр сургалт хийж, хүүхдийн нас баралтын 1 тохиолдолд задлан шинжилгээ хийж, 2018-2019 оны эмнэлгийн нас баралтын өвчний түүхүүдэд үнэлгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгөв.

МУЗГ-ын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын 4-р судалгаа”-нд 15-69 насны нийт 6780 хүнийг хамруулан, 377 кластер буюу газар нутагт хийгдэнэ. Судалгаанд Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан, Эрдэнэ, Сайншанд сум сонгогдсон бөгөөд эдгээр сумын нийт 6360 өрхийн судалгааг авч, НЭМҮТ-д хүргүүлээд байна.

Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын албан даалгаварыг анхан шатны 16 ЭМБ-уудад хүргүүлж, 4 багцийн тусламж үйлчилгээний эхний 5 сарын гүйцэтгэлийг эмнэлэг тус бүрээр гарган, анхаарах шаардлагатай зөвлөмжийг хүргүүлэн өдөр дутам хяналт тавих зэргээр үзлэгийг эрчимжүүлснээр эхний хагас жилийн гүйцэтгэлээс 21,6%-г нэмэгдүүлсэн.

Улаанбурхан улаануудын дархлаажуулалтанд 9088 хүнийг хамруулан хамралтыг 93.9% хүргэсэн.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж ЭМС-ын 8 байгууллага сайн үйлсийн аянд нэгдэж сайншанд сумын зорилтот бүлгийн 13 өрхийн 18 хүүхдэд эд материалын тусламж үзүүлсэн.

Эрүүл мэндийн газрын ажилтан албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдийн дунд тэмцээн уралдаан зохион байгуулж, 0-16 хүртэлх насны нийт 40 хүүхдэд байгууллагын үйлдвэрчний хорооноос бэлэг гардуулан баярын арга хэмжээг аймгийн гэр бүлийн талбайд зохион байгуулсан.

“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийгдэж буй тул үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний

биелэлтийн тайланг 2017 оноос 2019 оны эхний 5 дугаар сарын байдлаар бичиж, ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй 2,8 сая төгрөгийн БЗДХ-ын эмчилгээний эм, тэмбүүгийн оношлуурыг ЭМГ-ын даргын А/77 дугаар тушаалаар Аймгийн 2 нэгдсэн эмнэлэгт хуваарилсан.

Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2019 оны хэрэгцээт жирэмслэхээс хамгаалах эм хэрэгслийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулах тухай ЭМГ-ын даргын А/ 75 дугаар тушаалыг батлан байгууллагуудад хүргүүлэв.

Герман улсын Эрүүл мэндийн “В, С вирусын дамжих замын эрсдэл, халдварын сэргийлэлт хяналт” төсөл хөтөлбөр 2019 оны 1 сарын 1-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийн дагуу герман улсын 3 төлөөлөгч, Medclean ХХК захирал, 1 мэргэжилтний хамт Аймгийн нэгдсэн эмнэлгийн 5 тасгийн халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаатай танилцаж зөвөлгөө өгсөн.

Сүрьеэгийн сорьц тээвэрлэх үйл ажиллагаанд хийсэн дэмжлэгт хяналтын зөвлөмжийг Айраг, Даланжаргалан сумдын эрүүл мэндийн төвд хүргүүлсэн.

ЭМС-ын 2019 оны 11 дугаар албан даалгаврын дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 30 эмч, мэргэжилтнүүдэд “Тарваган тахал өвчний төлөв байдал, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, халдвар хамгааллын дэглэм баримтлах, хүн амд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажил үр дүнтэй зохион байгуулах” тухай зааварчилгаа өгч, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

Дорноговь аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн Гол аймаг хоёр нь хил нийлэн оршдог найрсаг хамтын ажиллагааны хүрээнд Хөх хотын монгол эмнэлэг дээр ажлынажлын байрны 14 хоногийн сургалтанд төв, хөдөөгийн 9 эмч, мэргэжилтэнг хамруулж байна.

Биеийн тамир,спортын газар:

2019 оны 09 дүгээр сарын 08-15ндУлаанбаатар хотод болох Монголын хүүхдийн спортын 6-р Их наадамд Дорноговь аймгаас оролцох шигшээ багийн тамирчдын мэдүүлгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-т 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр цахимаар хүргүүлэв.

2019 оны 06 дугаар сарын 12-14, 06 дугаар сарын 28-30 өдрүүдэд БНХАУ ын Эрээн хотод спортын нөхөрсөг уулзалт, тэмцээнд Дорноговь аймгаас спортын 5 төрлөөр 48 тамирчинг бэлтгэн хамруулсан. Холимог волейболын төрөлд алтан медаль, хийн

дасгалын төрөлд алтан медаль, ширээний теннисний хос болон холимог хосын төрөлд алт, мөнгө, хүрэл медалиуд хүртсэн амжилт үзүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 тогтоолын дагуу Монголын “Тамирчдын өдөр”-ийг “Олон улсын олимпийн өдөр”- тэй хамтатган 2019 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Сайншанд хотод зохион байгуулсан. Уг өдрөөр “Идэвхитэй хөдөлгөөн- Эрүүл амьдрал” өглөөний дасгал, 3х3 Сагсан бөмбөг, Волейболын тэмцээн, Спорт-Олимпизмын холбогдолтой АХА тэмцээнийг зохион байгуулж, 38 байгууллагын нийт 230 гаруй тамирчид оролцсон.

3. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр:

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр:

- Хууль тогтоомжийн биелэлт, Засгийн газрын тогтоол шийдвэр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргасан.
- 2019 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.
- 2019 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэж буй компаниудад урьдчилгаа санхүүжилт болон гүйцэтгэлийн санхүүжилтэд 2.1 тэрбум төгрөгийг хуваарилан олгосон.
- Сайншанд сумын 7-р багийн ИХТ-ийн барилгын санхүүжилтээс 2018 оны 12-р сард авч үлдсэн 5.9 сая төгрөгөөр Дэлгэр баясах зам ХХК-иар дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр аймгийн ЗД-ын захирамж боловсруулж, гэрээ байгуулан ажлыг хийлгэж байна.
- 3 компанийн ирүүлсэн хүсэлтийг үндэслэн ГХБХБГ-аас дүгнэлтийг авч гэрээний хугацааг сунгасан.
- Сайншанд сумын хуучин орон сууцнуудын дээвэр дулаалга фасад засварын ажлын 2, 3, 4-р багцын гүйцэтгэгчээр шалгарсан ТОВЭМ, Дэнжийн хүү, Жой скай зэрэг компанитай гэрээ байгуулсан.
- Хөвсгөл сумын 200 хүний суудалтай Соёл спортын төвийн барилгын гүйцэтгэгчээр шалгарсан Хар хорин өргөө ХХК-тай гэрээ байгуулсан.
- Аймгийн төвийн 1-р зэрэглэлийн зарим хэрэглэгчийг цахилгааны нөөц эх үүсвэрээр хангах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Лайшил ХХК-тай гэрээ байгуулсан.
- Сайншанд сумын 1000 хүний суудалтай Спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч Болор аграмба ХХК-ийн санхүүжилтийн материалыг бүрдүүлэн энэ онд батлагдсан санхүүжилтийг авахаар Сангийн яаманд материалыг хүргүүлсэн.
- Аймгийн ОНХС-аас санхүүжих 3 ажилд 138.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Хуучин орон сууцнуудын дээвэр дулаалга фасад засварын ажлын гүйцэтгэгч компаниудад гэрээнд заасны дагуу 89.9 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон.
- Тодотголоор батлагдсан зарим сумдын наадмыг тохиолдуулан олгож буй дэмжлэгийг сумдын нэмэлт дансанд санхүүжилтийн эрхийг нээсэн.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас орж ирсэн зарим ажлын захиалагчийн хяналтын зардлын 70, 30%-ийг холбогдох байгууллагуудад олгосон.
- Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж, ХШҮДАХ-т хүргүүлсэн.

Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр:

- Аймгийн Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах байнгын ажиллагаатай зөвлөлийн эхний хагас жилийн тайланг БХБЯ, Улсын ГХГЭББАЗөвлөлд хүргүүллээ.
- Газрын тос боловсруулах үйлдвэрийн зориулалтаар Алтанширээ сумын нутаг дэвсгэрт 255 га газрыг нэмж улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг боловсруулж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 11/04 тоот тогтоолыг ГЗБГЗЗГ, БХБЯ-нд хүргүүлсэн.
- Засгийн газрын 2019.04.03-ны өдрийн Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 129 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сайншанд сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт 11.08 га газрыг аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар 13-ны өдрийн А/520 дугаар захирамжаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХК-д ажилчдын орон сууцны хотхоны зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн.
- Сайншанд сумын 3, 8 дугаар багийн хил заагийг баталгаажуулах асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж 06 дугаар сарын 10-ны өдрийн 11/08 тоот тогтоолоор шийдвэрлүүлсэн.
- Хөвсгөл, Улаанбадрах сумын хилийн цэсийн асуудлаар саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн саналыг БХБЯ, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.
- 50 ортой төрөх эмнэлгийн барилга угсралтын ажлын талаар ЭМЯ-ны сайд, гүйцэтгэгч компаний төлөөлөл оролцсон уулзалтыг зохион байгуулж, тус төрөх эмнэлгийн барилгын ажлын тендерийг ЭМЯ хариуцан зохион байгуулахаар Эрүүл мэндийн сайд шийдсэн.
- Аймгийн ИТХТХ болон ИТХ-аар хэлэлцүүлэх 8 асуудлын танилцуулга холбогдох материалыг бэлтгэж хүргүүлэв.
- Дэлгэрэх сумын соёлын төвийн барилга угсралтын ажилд гарсан зөрчлийг арилгасан ажлын тайлантай танилцаж гүйцэтгэгчтэй уулзан ажлын чанар гүйцэтгэлийн талаар зөвлөмж өгсөн.
- Айраг сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт Нарны станцын зориулалтаар 40 га, хөргүүртэй болон энгийн агуулахын зориулалтаар 1,5 га, төмөрлөгийн хүдэр баяжуулах үйлдвэрийн зориулалтаар 16 га газарт төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан журмыг зөрчиж явуулсан АТГ-ын мэдэгдлийн дагуу уг газрыг хүчингүй болгож хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллах тухай үүрэг чиглэлийг аймгийн Засаг даргаас Айраг сумын Засаг даргад хүргүүлсэн.
- Монгол улсын Засгийн газрын тогтоол болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг гаргасан.
- Барилгын ажлын зөвшөөрөл олголтын судалгаа мэдээллийг гаргаж Татварын хэлтэст хүргүүллээ.
- Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх хүсэлтийг хүлээн авч судлан 15 иргэн, ААНБ-д барилгын ажлын зөвшөөрөл олгосон.
- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх ашиглуулах чиглэлээр аймгийн Засаг даргын 11 захирамж шийдвэр гарсан байна. “Хот байгуулалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаж саналаа БХБЯ-нд хүргүүлсэн.
- Хатанбулаг сумын Спорт цогцолборыг 2019 онд багтаан ашиглалтад оруулах асуудлаар орон нутгийн саналыг БСШУЯ, Сангийн яаманд хүсэлт хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг хүлээн авах ажлыг зохион байгуулсан.

- Аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэнгийн зураг төслийг хүлээн авч, Хүүхдийн паркийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод тусгах саналыг боловсруулсан.

Байгаль орчны чиглэлээр:

- Даланжаргалан, Айраг, Эрдэнэ сумдад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 4 тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон.

- Монгол улс, Бүгд Найрамдах Хятад ард улс болон Оросын холбооны улсын аялал жуулчлалын сайд нарын 4 дүгээр хуралдааны үеэр зохион байгуулагдсан, “Цайны зам” соёл аялал жуулчлалын хөгжлийн шинэ чиг хандлага форум болон “Цайны зам” соёл, аялал жуулчлалын үзэсгэлэн ӨМӨЗО-ны Улаанцав аймаг Жинин хотод зохион байгуулагдаж аймгийн Засаг даргын орлогч болон БОАЖГ-ын дарга, мэргэжилтний хамт оролцсон. Тус арга хэмжээ нь Цайны замын бүсийн худалдааны эргэлтийг хурдасгах, харилцан хамтын ажиллагааг бэхжүүлэх, соёлын өвийг сурталчлан таниулах, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ач холбогдолтой юм.

- 6 сарын 28-ны өдөр Эрдэнэ сумын Хунхат нэртэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт хийж үйл ажиллагааг зогсоосон.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийнхуралдаанаар аймгийн тусгай хамгаалалтад байх хугацаа дуусах 2 газрын хугацааг сунгах, “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах булшлах журам”, “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, Энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф”, “Мод тарьж ургуулсан иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ыг хэлэлцүүлэн батлуулсан. Мөн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох 4 газрыг хэлэлцэн саналыг дэмжсэн.

- Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний сургалт 10-наас эхлэн 4 хоногийн хугацаатай явагдаж 9 мэргэжлээр 180 хүн суралцаж мэргэжлийн үнэмлэхээ гардан авсан.

- 06 дугаар сарын 12-ны өдөр МУИС-ийн Ази тэнхимийн судлалын доктор, дэд профессор Ш.Эгшиг багшийг урин авчирч "Цайны замын аялал жуулчлалыг хөгжүүлэх нь" сэдэвт илтгэл, лекцийг зохион байгуулж нийт 170 хүнд мэдээлэл өгсөн.

- Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших Цагаан дэлийн агуйг өнгөрсөн 5 дугаар сард УИХ-ын тогтоолоор дурсгалт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсантай холбогдуулан Цагаан дэлийн агуйг нөхөн сэргээх зорилгоор сумын удирдлагууд, холбогдох чиг үүргийн байгууллагууд болон агуйн орчимд жонш олборлолтын үйл ажиллагаа явуулдаг 10 компанийн удирдлагуудтай 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдөр уулзалт

хийж агуйн амны хэсгийг хэвийн байдалд оруулах, ойр орчмын газрыг нөхөн сэргээх, эргэн тойрны хашааг засварлан өргөтгөх, камер суурилуулж байнгын харуул хамгаалалттай болгох талаар хэлэлцэж, ирэх 7-р сард багтааж засварлах үүрэг чиглэлийг холбогдох хүмүүст өгсөн.

Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

- 14-15-ны өдрүүдэд Шанд бороо-1 экспедиц Хатанбулаг-Хөвсгөл-Улаанбадрах сумдын нутгаар, Шанд бороо-2 экспедиц Сайхандулаан-Сайншанд-Өргөн сумдын нутгаар цаг

агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэн ажиллалаа. Үйл ажиллагааны үр дүнд Сайншанд суманд 6.8мм, Замын-Үүд суманд 1.7мм, Дэлгэрэх суманд 4.1мм, Хөвсгөл суманд 8.6мм, Эрдэнэ суманд 7.2мм, Алтанширээ суманд 0.4мм, Иххэт суманд 2.6мм, Өргөн суманд 13.0мм, Улаанбадрах суманд 17.8мм, Хатанбулаг суманд 2.3мм бороо орсон.

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн төлөө хамтдаа” хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан “Иргэн бүр санаачлагч-Өрх бүр үйлдвэрлэгч” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХТ-ийн 2019 оны 63 дугаар тогтоолоор батлуулсан.

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар албан даалгаврыг холбогдох газарт хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах үүрэг чиглэл болгосон.

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг дарга нарын 2019 онд хамтран хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээний хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гарган хүргүүлсэн.

- 2019 онд 10 сумын үүсгэн байгуулагдсаны түүхт 95 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан сумдад баяр наадмыг зохион байгуулалтын өндөр хэмжээнд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэхийг үүрэг болгосон.

- Сайхандулаан, Даланжаргалан, Айраг, Алтанширээ, Иххэт, Дэлгэрэн сумдад мал, амьтны гоц халдварт шүхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг 21 хоногт багтаан зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2019 оны А/524 дүгээр захирамж гарсан.

- “Иргэн бүр санаачлагч-Өрх бүр үйлдвэрлэгч” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулахаар хүргүүлсэн.

- Аймгийн Засаг даргын 2019 оны А/377 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, захцуулалт, хэрэгжилт, үр дүн”-гийн байдалд улсын үзлэг зохион байгууллаа. Улсын үзлэгт хамрагдсан 14 сумын “Сум хөгжүүлэх сан”-гийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд муу буюу 40-59 оноогоор Сайхандулаан, Дэлгэрэх, Айраг, Алтанширээ сумд, дунд буюу 60-79 оноогоор Хатанбулаг, Улаанбадрах, Замын-Үүд, Өргөн, Сайншанд, Эрдэнэ сумд, сайн буюу 80-89 оноогоор Хөвсгөл, Иххэт, Даланжаргалан сумд тус тус үнэлэгдсэн байна.

- Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөрийн тайланг 2019 оны эхний хагас жилийн байдлаар гарган ХХААХҮЯ-нд хүргүүлээ.

- “Шинэ хөдөө” төслийн хүрээнд Айраг, Даланжаргалан, Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх, Өргөн, Сайхандулаан, Мандах сумдад инженерийн хийцтэй худаг, мал угаалгын суурин ванн, нийлэг хальсан хүлэмжийн иж бүрдэл, вакцин хадгалах стандартын шаардлага хангасан хөргүүр, хадлангийн трактор, хадуур тарсмуур, хаман боогч, нэхий элдэгч машин,суурин компьютер олгохоор шийдвэрлэсэн ба тендерийн материалыг бэлтгэн холбогдох газарт хүргүүлсэн.

Зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны чиглэлээр:

- МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт гаргасан.

- Эрчим хүчний сайд аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний биелэлт гаргаж хүргүүлсэн.

- 2019 онд Авто замын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын мэдээллээр ТВ-д мэдээлэл өгсөн.
- Дэлгэрэх суманд халаалтын зуух, инженерийн шугам сүлжээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх асуудлыг аймгийн ИТХТэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулсан.
- Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдын төвд нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үнэ төлбөргүй, оюутан, сурагчдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчуулах журам” төслийг шинэчлэн боловсруулж аймгийн ИТХурлаар батлуулсан.
- Хот суурин газрын ус, дулаан хангамж, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах төлөвлөгөөг батлан холбогдох сумд, агентлагт хүргүүлэн чиглэл өгч ажиллав.
- Аймгийн төвд Автовокзал шинээр баригдаж ашиглалтад орсонтой холбогдуулан Автотээврийн төвийн өрөөний тохижилтод 3,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргуулсан.

4. Санхүү, төрийн сангийн чиглэлээр:

- Төрийн албан хаагчийн хувийн хэргийг баяжуулсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсний жишгийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын өсөлтийг шийдвэрлэх, орон нутгийн төсвийн өмнөх оны үлдэгдлийг 2019 оны төсөвт бүрэн тусгах, төсвийн жилд үүссэн тогтмол зардлын өрийг барагдуулах зорилгоор ерөнхийлөн захирагчийн төсөв хооронд зохицуулалт хийн аймгийн 2019 оны орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Аймгийн Засаг даргын 2019 оны 6 сарын 5-ны өдрийн 1/1074 албан бичгээр хүргүүлж ажилласан.
- Албан тушаалын тодорхойлолтыг pdf файлаар шинэчлэн хийсэн.
- Шилэн дансны мэдээллийн системд 5 сарын мэдээллийг бүрэн байршуулсан.
- Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 37 төсөвт байгууллагын данс, 37 нэмэлт төсвийн данс, 25 сангийн данс нийт 99 дансны зарлагын гүйлгээг програмд шивэж төв төрийн санд дамжуулж, төлбөрийн баримтын архивын нэгж үүсгэн ажиллаж байна.
- Сумдын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээнд e-report системээр хяналт тавьж алдаа зөрчлийг залруулсан.
- Ерөнхий орлогын дансанд 278 сая төгрөг төвлөрүүлж Орлоготой уялдуулан төсвийн байгууллагуудын санхүүжилтийг эрэмбэлэн олгож байна.
- Алтанширээ сумын ЗДТГ-ын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга, Дэлгэрэх сумын Бумбат багийн дарга нарт өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмж нийт 17.6 сая төгрөг олгосон.
- 2018 оны санхүүгийн тайланд хязгаарлалттай, сөрөг дүгнэлт авсан дарга, санхүүгийн ажилчдад хариуцлага тооцох тухай захирамжийн төслийг боловсруулан сонсох ажиллагааг хийсэн. Сахилгын шийтгэл хүлээн авах үндэслэлгүй гэж үзсэн 4

байгууллагын зөрчлийг дахин нягтлах талаар төрийн аудитын газарт бичиг хүргүүлсэн.

- Нэмэлт санхүүжилтийн эрхийг нээхдээ Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 74 тушаалыг үндэслэн 15 удаагийн хүсэлтээр 24.7 сая төгрөгийн баримтын бүрдлийг хянаж нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж эрх нээсэн баримтыг архивын нэгж үүсгэн ажиллаж байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 21 ААНБ, 3 цэргийн ангид нийт 1.974 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Замын сангийн хөрөнгө оруулалтаар 4 ААНБ ЗДТГ, ГХБХБГ-т нийт 231 сая төгрөгний санхүүжилтийг олгосон.
- 2 аж ахуйн нэгжийн албан хүсэлтээр жилийн эцсийн санхүүгийн тайланд засвар хийж , 1 аж ахуйн нэгж татан буугдаж холбогдох материалыг үндэслэн E-balance системээс хасалт хийж ажиллаа
- 6 аж ахуйн нэгж байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд засвар хийсэн.
- Засаг даргын дэргэдэх захиргааны зөвлөлд ирүүлсэн эд хөрөнгийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх бичгийг Прокурорын газар хүргүүлсэн.
- Хэлтэст нийт 19 бичиг ирсэнээс 19 бичгийг албан хэрэгцээнд авсан.
- Аймгийн ерөнхий орлогын дансанд 2628.9 сая төгрөг төвлөрүүлж 85 хувийн хөрөнгө оруулалтад, 15 хувийг сумдын санхүүжилтийн дэмжлэгт олгосон. Үүнд: Орон нутгийн хөрөнгө оруулалтад 2234.5 сая Сумдын санхүүгийн дэмжлэгт 411 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон. Төрийн аудитын газрын 2019 оны 1-6/460 тоот албан хүсэлтийн дагуу 2018 оны санхүүгийн тайланд хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан сумдын төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчдад сануулах арга хэмжээ, санхүүгийн ажилчдад хариуцлага тооцож ажиллах тухай, албан бичгийн хариуг Төрийн аудитын газарт тус тус хүргүүлсэн.
- Монгол Улсын Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан Иргэдийн Хурлын ээлжит 11-р хуралдаанаар орон нутгийн 2019 оны төсөвт нэмэлт өөрчлөлтийг орууллаа.
- Орон нутгийн төсвийн нэмэлт өөрчлөлтийг ИТХ-ын 2019 оны 6 сарын 10-ны өдрийн 11/09 тогтоолоор батлуулсан. Батлагдсан тогтоолын дагуу төсвийн төлөвлөтийн программд байгууллага тус бүрээр орлого, зарлагын хуваарийг эдийн засгийн ангиллаар шивж Сангийн яамны Төсвийн бодлогын газарт өгч татуулах ажил хийгдэж байна.
- Монгол улсын зүүн бүсийн таван аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийнхэн бид жил бүр ажлын арга туршлагаа солилцох нөхөрсөг уулзалт, спортын арга хэмжээг хуваарийн дагуу Сүхбаатар аймагт 2019 оны 06 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд оролцсон.
- Сумдын санхүүгийн алба, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч , няравуудыг мэргэшүүлэх сургалтыг Замын-Үүд сутманд амжилттай зохион байгуулсан.

- Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан бусад чиг үүргийн ажлыг хийж гүйцэтгэлээ

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц: Улс ба орон нутгийн төсөвт 1708000,0 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.

Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 5 төрлийн нийт 31289 татварын тайлан, 3 төрлийн нийт 23 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн. Тайлант сард нэг цэгийн үйлчилгээний өрөөгөөр утсаар болон биечлэн 903 татварт төлөгчдөд татварын хуулийн болон Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийлээ. Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 9 хуулийн этгээд болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн 5 татвар төлөгчдийн мэдээллийг хүлээн авч, НӨАТ төлөгчөөр шинээр бүртгэгдсэн 8 татвар төлөгчийн мэдээллүүдийг баазад тухай бүр шивж оруулан шинээр үүсэж байгаа татвар төлөгчдөд татварын багц хуулиар зөвлөгөө өгч ажиллалаа. НӨАТ суутган төлөгчийн тоо - 345 үүнээс пос 315 шинээр 3 иргэн пос хэвлэж нэмэгдсэн мөн төлбөрийн баримт олгоогүй болон олгосонч илгээгээгүй төлөвтэй 4 татвар төлөгчдөд шаардлага гардуулан ажилласан.

Татварын ерөнхий газрын даргын Н/40 дүгээр тушаалаар баталсан “2019 оны эхний хагас жилд хяналт шалгалтанд хамруулах эрсдэл бүхий татвар төлөгчийн төлөвлөгөө” Татварын хэлтсийн даргын баталсан удирдамж болон татвар төлөгчөөс хасагдах хүсэлтийн дагуу 16 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулсан.

Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, нуугдмал орлогын эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд 5 байгууллагаас 226,39 сая төгрөгийн 30 мэдээллийг цуглуулж нэгтгэн тасгуудыг мэдээллээр ханган ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 22 төлбөр төлөгчөөс 1 төлбөр төлөгчийн 1,0 сая/төг-ийг хэсэгчлэн, 2 төлбөр төлөгчийн 3,0 сая/төг-ийг бүрэн барагдуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албатай тооцоо нийлж ажиллалаа.

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд өр барагдуулахаар нэхэмжилсэн 1 төлбөр төлөгчийн 1,9 тэр/төг-ийн шийдвэрийг татварын хэлтсийн талд 100 хувь төлүүлэхээр шийдвэрлүүлээ.

Эх үрсийн баяраар 10 албан хаагчийн 19 хүүхдийг баярлуулан гарын бэлэг өглөө.

Тайлант сард Хэлтсийн даргын 2019 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу 4 албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүллээ.

Татварын ерөнхий газраас Дорнод аймагт 2019 оны 06 сарын 14-өөс 19-ны хугацаанд зохион байгуулагдсан “Татварын шинэчлэл-2019” Татварын шинэчлэгдсэн багц хуулиуд, хууль хэрэгжүүлэх 49 журам, татварын удирдлагын нэгдсэн системийн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт 17 албан хаагч хамрагдуулсан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд 4 албан хаагч хамрагдсан.

Татварын ерөнхий газрын Сургалтын төвөөс 2 жилд 1 удаа зохион байгуулдаг мэргэшүүлэх онлайн сургалтанд 34 татварын улсын /ахлах/ байцаагч нарыг хамруулж, хамрагдалтанд хяналт тавин ажиллаж байна. Мэргэшүүлэх шалгалтын онооны нэг хэсэг болох бие даалтыг 6 тасгийн 34 албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийн дагуу Сургалтын төвөөс хуваарилсан сэвдийн хүрээнд хийж Татварын ерөнхий газарт хүргүүллээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба:

1. *Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:* Албаны дарга аймгийн Засаг даргатай 2019 оны төлөөлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. *Цаг үеийн ажлын мэдээлэл:* Аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар удирдамжийн дагуу Саранхөхөө театрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

Аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 08 дугаар удирдамжийн дагуу Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг мөн үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

Аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 2019 оны 06 сарын 13-ны өдрийн 10 дугаар удирдамжийн дагуу Алтанширээ сумын төсөвт байгууллагуудын 2017-2018 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2019 оны 06 сарын 14-ний өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдөр хүртэл хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Албаны дарга Х.Оюунтуяа 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Сангийн яаманд “Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдах ажилтны сургалт”-д хамрагдаж, 3 асуудлыг бодлогын түвшинд тавьж хэлэлцүүлээ.

Албаны мэргэшсэн нягтлан бодогч Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Б.Золзаяа, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Н.Бүрэнтэгш нар Баянхонгор аймагт болсон “Мэргэшсэн нягтлан бодогчдын тасралтгүй боловсрол” сургалтанд 2019 оны 06 сарын 05-ны өдрөөс 06 сарын 10-ны өдрүүдэд хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга бөгөөд салбар комиссын даргын баталсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулах хуваарь”-ийн дагуу 2019 оны 06 сарын 03-ны өдөр Ч.Чулуунцэцэг, М.Нандинцэцэг, Р.Энхбаяр нар тус байгууллагад ажилласан.

Энэ сард байгууллагын даргын А тушаал 3, Б тушаал 1-ийг төлөвлөн баталж, 19 албан бичиг ирснийг бүртгэж, 30 албан бичгийг төлөвлөж, холбогдох газар руу нь хүргүүлж ажиллалаа.

Статистикийн хэлтэс:

Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:

Сар бүрийн хөдөө аж ахуйн мэдээ тайланг 64 багаас, аж үйлдэрийн салбарын мэдээг 60 гаруй аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч, нягтлан шалгаж программд шивж дамжууллаа.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2019 оны 05 сарын танилцуулга болон илтгэлийг бэлтгэж цахимаар хэрэглэгчдэд тархааж, мөн хэлтсийн facebook болон цахим хуудсанд байршуулан Б.Баяржавхлан орон нутгийн DTV телевизэд мэдээлэл хийсэн.

ҮСХ-ны эдийн засгийн статистикийн газраас малын хагас жилийн түүвэр судалгааны хяналтаар ахлах шинжээч Р.Энх-Амгалан шинжээч Д. Ганзул, хэлтсийн ахлах мэргэжилтэн Б. Цэрэндорж, судлаач Б. Мөнх-Эрдэнэ нар Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ сумдад 6-р сарын 5-7 ны өдрүүдэд ажилласан.

Архивын үзлэгийн хүрээнд Ц.Сансармаа даргатай аймгийн ажлын хэсэг байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа, архив албан хэрэг хөтлөлтөнд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдал, төрийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт зэрэгт 85,0 хувийн үнэлгээг өгч, заавар зөвлөмж өгч ажилласан.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг хугацаанд нь бичиж программд оруулан, 06-р сарын 05 ны өдөр баталгаажуулсан.

Аймаг, сумдын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 11-12 ний өдрүүдэд 170 хүнд амжилттай зохион байгууллаа.

Сургалтыг ҮСХ-ны Дотоод аудит, мониторингийн хэлтсийн дарга Б.Саранчимэг даргатай сургалтын баг бүрэлдэхүүн ирж сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын сумдын түр товчооны дарга нар, сумдын

Санхүүгийн албаны дарга буюу сумын тооллогын комиссын нарийн бичгийн дарга нар мөн төсвийн байгууллагын дарга, захирал, аж ахуй нэгж байгууллагын дарга захирал, эхлэгч нар оролцлоо.

Сургалтаар Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, сайжруулалтыг хийж гүйцэтгэх талаар, Байшин орон сууцны тооллогын тухай болон орон нутгийн статистикийн үйл ажиллагааг хариуцсан албан хаагчийн статистикийн мэдээг хийж гүйцэтгэхэд баримтлах хууль эрх зүй, аргачлал, арга зүйн мэдээлэл, заавар, зөвлөмжийг хүргэлээ.

Мөн 6-р сарын 13-15 нд Эрдэнэ суманд аймгийн ЗДТГ-аас зохион байгуулах багийн Засаг дарга нарын нэгдсэн сургалтын бэлтгэл ажлыг ханган ЗДТГ-тай хамтран хэлтсийн дарга Х.Өлзийсүрэн, Ахлах мэргэжилтэн Б.Цэрэндорж, мэргэжилтэн А.Амарзаяа нар ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан.

2019 оны 6-р сард Ажиллах хүчний судалгаа, Өрхийн нийгэм эдийн судалгаа, Сайншанд, Айраг, Дэлгэрэх, Хөвсгөл, Иххэт сумдын нийт 106 өрх хамрагдаж Үндэсний Статистикийн хороонд дамжуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Сар бүрийн 21 нд судалдаг 238 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвөөс, 142 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг 5 сумдаас авч мэдээний UNE7 програмд шивж хугацаанд нь ҮСХ-нд дамжуулсан.

6-р сарын 21 ны ББӨ-1, ОСҮ-1,ХСҮ-1, ҮСҮ-1, АҮСҮ-1 мэдээнүүдийг графикт хугацаанд шивж ҮСХ-нд дамжуулсан.

Байшин орон сууцны тооллогын зорилго нь аймгийн нутаг дэвсгэрт ашиглагдаж буй байшин, орон сууцны бүхий л сан хөмрөгийг буюу аймгийн иргэдийн амьдарч буй сууцны дэд бүтцийн нөхцөл, насжилт, хийц зэрэг мэдээллийг бүрэн тодорхойлох юм. Бэлтгэл ажлын хүрээнд Байшин орон сууцны 2019 оны тооллогын урьдчилсан бүртгэлийн программын талаарх сургалтыг online хэлбэрээр, сумдыг бүсчилэн 6-р сарын 20 ны өдөр зохион байгуулсан.

ҮСХ-ноос 2019 оны 06-р сарын 21 ны өдөр ХАӨМС-ын шинэчилсэн бүртгэлийн онлайн сургалтийг хийж сургалтанд хэлтсийн мэргэжилтэнгүүд бүгд хамрагдлаа.

Байшин орон сууцны 2019 оны тооллогын урьдчилсан бүртгэл 2019 оны 06-р сарын 24-нөөс 07-р сарын 05-ны хооронд “Collector for ArcGIS” программд ажиллаж сумдууд бүртгэл хийж эхэлсэн.

Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлт, Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт сэдэвт салбарын танилцуулгыг 2018 оны байдлаар бэлтгэн гаргаж хэрэглэгчдэд тархаав.

Орон нутгийн өмчийн газар:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарласан. Үүнд:

1. Дорноговь аймгийн Шинэ хөдөө төслийн хөрөнгө оруулалтын / Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан Багц-04, 05, 06/ ажил
2. Сайншанд суманд спорт талбай /2ш/ барих ажил
3. Замын-Үүд суманд спорт талбай /2ш/ барих ажил
4. Дорноговь аймгийн Шинэ хөдөө төслийн хөрөнгө оруулалтын / Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан Багц-03, 04, 05, 06/ ажил
5. Сайншанд сумын 1-р сургуулийн хөлбөмбөгийн талбайн шинэчлэлийн ажил.

6. Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд автомашин худалдан авах ажил 06.25-ны өдөр нээхэд оролцогч ирээгүй тул хүчингүй болон дахин зарласан.

7. Дорноговь Төмөр замын Орос давхарын дээврийн засварын ажил 06.26-ны өдөр нээхэд оролцогч ирээгүй тул хүчингүй болон дахин зарласан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд нээлт хийж тендерт нарийвчилсан үнэлгээ хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны их засварын ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

2. Замын-Үүд суманд Иргэдийн хөгжлийн төв барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

3. Хөвсгөл суманд соёл, спортын төвийн барилга барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

4. Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны их засварын ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

5. Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлыг нарийвчилсан үнэлгээ хийж байна.

6. Дэлгэрэх сумын 0,4квт-ын ЦДАШ-ын өргөтгөлийн ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

7. Эрдэнэ суманд спорт талбай барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

8. Хөвсгөл суманд соёл, спортын төвийн барилга барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд нээлт хийнэ. Үүнд:

1. Хөвсгөл сумын Эрүүл мэндийн өргөтгөлийн ажил

2. Алтанширээ сумын цэцэрлэгийн барилгын ажил

3. Хөвсгөл сумын Эрүүл мэндийн өргөтгөлийн ажил

4. Замын-Үүдийн иргэдийн хөгжлийн төвийн ажил

5. Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны их засварын ажил

6. Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд автомашин худалдан авах ажил

7. Дорноговь Төмөр замын Орос давхарын дээврийн засварын ажил

8. Мандах суманд цэцэрлэгийн барилга барих ажил
9. Сайншанд суманд спорт талбай барих ажил

Орон нутгийн өмчийн хүрээнд:

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг хянаж, батлуулах, ажлыг явагдаж байна. Байгууллагуудаас хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн саналыг хүлээн авч хуралд оруулахад бэлтгэж байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Орон нутгийн өмчийн газрын 2019 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу “Чандмань бадрал” ОНӨХХК, “Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК”-иудад 2019 оны 05 сарын 21-ны өдрөөс 2019 оны 05 сарын 24-ний өдрийг хүртэл ажилласан.

Зүүнбаян багт орон сууц хувьчлалын асуудлаар, Хөвсгөл сумын санхүүгийн албан хаагчдад орон нутгийн өмчийн харилцаа сэдэвт сургалт, Замын-Үүд суманд зохион байгуулагдсан аймгийн санхүүгийн ажилтнуудын сургалт зөвлөгөөнд орон нутгийн өмчийн харилцаа, өмчийн зохицуулалт, эд хариуцагч, өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа сэдэвт сургалт явуулсан.

8. Хууль эрх зүйн чиглэлээр:

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт, Монгол улсын хууль, тогтоомж, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Монгол улсын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлт, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт, Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт, Иргэн төвтэй төрийн үйлчилгээг дэмжих жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын гэрээний биелэлт зэрэг хагас жилийн тайлан мэдээг хуулийн хугацаанд цахимаар тайлагнасан.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/396 дугаартай захирамжаар томилсон Төрийн ажлын зохион байгуулалт, Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн салбар комисст хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, архивын тасгийн дарга нар ажиллаж 14 сумын Засаг даргын Тамгын газар, төсвийн байгууллага, 20 агентлагт шалгалт хийсэн.

Шалгалтыг Монгол улсын Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулах удирдамж”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Төв комиссын даргын баталсан “Улсын үзлэгийн дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал”-ын дагуу шалгасан.

Аймгийн хэмжээнд нийт Төрийн аудитын газар, 14 сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 агентлаг, 12 төсөвт байгууллага, 9 төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид улсыг үзлэг явууллаа.

Үзлэгт хангалтгүй бэлтгэсэн 3 байгууллагад архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага өгч, Нийтлэг үйлчилгээний газрын хэвлэмэл хуудас хэвлэх үйл ажиллагааг Улсын байцаагчийн акт хүргүүлж, түр зогсоов.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/488 дугаар захирамжаар Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулахад шаардагдах зардалд 2.3 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг иргэдэд танилцуулах, иргэдээс санал авах ажлын хэсэгт ажиллаж 8 суманд 3 өдөр ажиллаж иргэдэд хуулийн өөрчлөлтийг танилцуулж, санал авч Улсын Их хурлын Тамгын газарт тайланг хүргүүлж ажилласан.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/471 дугаартай Эрх зүйн боловсролыг иргэн бүрт өдөрлөг зохион байгуулах тухай захирамжаар Сайхандулаан, Мандах, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл сумдад ажилласан.

Өдөрлөгөөр хууль сахиулах чиг үүргийн 11 байгууллагын 25 алба хаагчид ажилласан ба иргэд, төрийн албан хаагч, төгсөх ангийн сурагчдад эрх зүйн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, 630 иргэнд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хууль зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Дорноговь аймгийн Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн салбартаа олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй хамт олноо тэргүүлэн ажиллаж байгаа Цагдаагийн газрын 12 алба хаагчдыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”, “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнах Аймгийн Засаг даргын шийдвэрийг гаргасан.

Мөн Цагдаагийн байгууллага нь түүхт 80 жилийн ойг тохиолдуулан албаны байрны засвар, гадна талбайн тохижилтыг хийж гүйцэтгэсэн байна.

Цагдаагийн байрны засварт “Дорноговь их хөгжлийн сангаас” 250 000 000 төгрөгийн санхүүжүүлсэн.

Мөн Улаанбаатар-Замын-Үүдийн чиглэлийн тус аймгийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрдөг босоо тэнхлэгийн авто замд тээврийн хэрэгслийг бүртгэх, зөрчил илрүүлэх хяналтын камер суурилуулах, байнгын хяналтын цэгийг камержуулах зорилгоор Цагдаагийн Ерөнхий газар, Оргил Дельта ХХК, Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газраас хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулан 74,968,300 төгрөгийн санхүүжилтээр тус замыг камержуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Архивын тасаг:

Дорноговь аймгийн төрийн архивын сан хөмрөгт 2019 онд нөхөн бүрдүүлэлт хийх ажлын график”-ийг дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2009-2012 оны 31 хн, Эрдэнэ сумын Соёлын төвийн 2006-2011 оны 31 хн-ийн байнга хадгалах баримт хүлээн авч, акт үйлдэж, хадгаламжийн санд байрлуулсан.

Төрийн архивын дэргэдэх ББНШАЗК-ын 3 дугаар хурлыг төлөвлөгөөг гаргаж, 12 байгууллагын 35 тоо бүртгэлийн баримт бичгийг комиссын гишүүдээр хянуулж, саналыг авч нэгтгээд байна.

Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дэргэдэх "Байгууллагын архивын баримтыг гэрээгээр цэгцлэх Ажлын хэсэг"-ийн архивч нар Сайхандулаан, Дэлгэрэх сумдын ерөнхий боловсролын сургууль, архивын баримтад иж бүрэн нягтлан шалгах ажил хийж, данс бүртгэлийг үйлдсэн бөгөөд одоо Айраг сумын ЗДТГ-ын архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт хийсэн.

Аймгийн Архивын тасагт 90 иргэн, 3 байгууллагаас өргөдөл, хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 39 архивын лавлагаа, тодорхойлолт олгож, 62 иргэнд 140 архивын баримтын хуулбар олгож үйлчилсэн.

Архивын тасгийн цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу Анагаах ухааны коллеж, Мод боловсруулах үйлдвэр зэрэг хөмрөгийн захирамжлалын баримт бичиг программд шивж, цахим мэдээллийн сан үүсгэв. Аймгийн ЗДТГ-ын 41 хн-ийн 6532 хуудас баримтыг фото шоп программын тусламжтайгаар засварлаж ашиглалтын хувь үйлдэв.

Архивын тасгийн цахимжуулалтын ажлын сарын мэдээг Архивын ерөнхий газарт хүргүүлэв.

9. Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр:

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний 2018 оны дүнгээр "шилдэг аймаг" болсонтой холбогдуулан, агентлаг, байгууллагын дарга нарт хүндэтгэл үзүүлэх аздтг-ын даргын 2019 оны 06 сарын 05-ны өдрийн а/66 дугаар "гарын бэлэг гардуулах тухай" тушаалыг төлөвлөн, гаргаж, бэлэг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Байгууллагын дотоод журмын төслийг боловсруулан, хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлуулж, тзух-т хүлээлгэн өгсөн.

Аймгийн засаг даргын захирамжаар батлагдсан архивын улсын үзлэгийн ажлын хэсэгт хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар ажиллаж 13 агентлаг, 6 сумын здтг, итх болон төсөвт байгууллагын архив, албан хэргийг шалган, туслах үйл ажиллагаанд оролцсон.

Байгууллагын архивын үзлэгийн комиссын бүрэлдэхүүнд хэлтсийн мэргэжилтэн ажиллаж, 2015 оны 5-7 сарын засаг даргын тушаалуудыг скайнердах, засварлах, хадгалах зэргийг хийж гүйцэтгэсэн.

Хэлтсийн албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн баяжуулж, төрийн албан хаагчийн анкет, хувийн хэргийн товъёог, хувь хүний намтар, шагнал авсан тухай нотлох баримт зэргийг шинэчлэн хувийн хэрэгт баяжилт хийх, албан тушаалын тодорхойлолтыг pdf хэлбэрт шилжүүлэх зэрэг ажлыг хийж, тзух-ийн хүний нөөц хариуцсан мэргэжилтэнд өгсөн.

Архивын улсын үзлэгийн ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн дагуу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн засаг даргад танилцуулан, тайланг онөг, хохбтх, стсх-т хүргүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, статистикийн хэлтэс, стандарт хэмжил зүйн хэлтэст явцын хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, зөвлөмжийг аздтг-ын даргын албан бичгээр хүргүүлсэн.

Монгол улсын шадар сайдын тушаал 1, засгийн газрын тогтоол 8 тогтоол, аймгийн итх-ын тогтоол 14-ийг хяналтанд авч, удирдлагуудад танилцуулан, холбогдох мэргэжилтнүүдэд хувиалан хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлийн 8 бодлогын баримт бичгийг хяналтад авч, хавтасжуулж, 2015 оны архивын улсын үзлэгийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар азд-ын 2016 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчийн “гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хагас жилээр тайлагнан, тзух-т хүргүүлсэн.

Хэлтэст 06 сард ирсэн 22 албан бичгийг холбогдох мэргэжилтнүүдээр хаалган, эх бичгийг архив бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн. Тайлан мэдээг хэлтсийн албан хэрэгцээнд авч нэгтгэсэн.

Үндсэн хуулийн хэлэлцүүлэг явуулах ажлын хүрээнд сайхандулаан, мандах сумдад ажилласан.

Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангуудыг 2019 оны 2 дугаар улирлын байдлаар нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, азд-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, згхэг-ын unelgee.gov.mn цахим санд шивж, баталгаажуулсан. Тайлан, хурлын тэмдэглэлийн хамт аздтг-ын даргын 2019 оны 06 сарын 28-ны өдрийн 3/1202 тоот албан бичгээр згхэг-т хүргүүлсэн.

Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон дорноговь аймгийн засаг даргын хооронд 2019 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн

Мянганы сорилтын сангийн судалгааны багийг тус аймагт ажиллах боломж нөхцлөөр ханган, суудлын авто машин засварладаг цэнэг, ганган зээрд зэрэг газруудтай уулзуулж, судалгаанд хамруулсан.